





INTOSAI Development initiative -IDI
Аудитын дээд байгууллагуудын
олон улсын байгууллага -
Хөгжлийн санаачлага

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТ: ЗААВАР, АРГА ЗҮЙ



Түршилтын хувилбар



АДБОУБ Хөгжлийн Санаачилга (АХС)
 АХС-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгын Аудитын Загвар (АТАЗ)
 IDI's SDG Audit Model (ISAM)
 Туршилтын хувилбар
 2020 оны 3 дугаар сар

Албан бус орчуулга – УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын дотоод мэдээллийн зорилгоор орчуулав
 Орчуулгын хувилбар 1 – 2021 оны 10 дугаар сарын 21

АГУУЛГА

ТОВЧЛОЛ 5

I БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТ: ТОДОРХОЙЛОЛТ, ГОЛ ЗАРЧИМ, АУДИТЫН ҮЙЛ ЯВЦ	9
1.1. ТХЗ-н зорилтод уялдсан үндэсний зорилт биелэлтэд гарсан ахицын аудит	9
1.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага ашиглах нь	11
1.3. Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим хэрэгжилтийн аудит	12
1.4. Олон талын хамтын ажиллагаанд аудит хийх нь	14
1.5. ТХЗ-ын хэрэгжилтийн аудит: АДБОУС-д нийцсэн, үр өгөөжид чиглэсэн гүйцэтгэлийн аудитын үйл явц	15
II БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН СУДЛАХ СЭДВИЙГ СОНГОХ	16
2.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг сонгох: Юуг, яагаад?	16
2.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг хэрхэн сонгох вэ?	17
2.3. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдэв сонгох	20
2.4. Аудитын үр өгөөж	20
III БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫГ ТӨЛӨВЛӨХ	21
3.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх: Юуг, яагаад?	21
3.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх: Үндэсний зорилтыг ойлгох нь	21
3.3. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад үр дүнд чиглэсэн болон тогтолцоонд чиглэсэн арга хандлагыг хослуулах нь	27
3.4. Аудитын хамрах хүрээг аудит хийх боломжтой байдлаар тодорхойлох	27
3.5. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зорилгыг тодорхойлох	28
3.6. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад тохирох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	29
3.7. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад аудитын загварын матриц боловсруулах	30
3.8. Аудитын төлөвлөгөөг эцэслэх	30
3.9. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх	31
3.10. Аудитын үр өгөөж	31
IV БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТ	32
4.1. Үндэсний зорилтыг биелүүлэхэд засгийн газраас хэрэгжүүлж буй уялдаа холбоог хангах чиглэлээр гаргасан хүчин чармайлтад аудит хийх	32
4.2. Үндэсний зорилтыг биелүүлэхэд олон талын хамтын ажиллагааг хангах тал дээр засгийн газрын гаргаж буй хүчин чармайлтад аудит хийх	33

Ерөнхий зүйл:

Энэхүү албан бус орчуулгыг Европын холбооны санхүүжилттэй Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд зөвхөн дотоодын хэрэгцээнд зориулан гүйцэтгэв. Тус баримт бичгийг зөвхөн Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын дотоодын хэрэгцээнд ашиглах бөгөөд гадагшаа түгээх, худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

4.3. Үндэсний зорилгыг биелүүлэхэд хэнийг ч орхихгүй байхын тулд засгийн газраас хэрэгжүүлж буй хүчин чармайлтад аудит хийх	33
4.4. Үндэсний зорилгыг биелүүлэх чиглэлээр батлагдсан багц бодлогын хэрэгжилтэд аудит хийх.....	34
4.5. Үндэсний зорилтын биелэлтэд гарсан ахицын талаархи аудитын нотлох зүйл цуглуулах	34
4.6. Үндэсний зорилтын биелэлтийн явцын талаархи аудитын нотлох зүйлд дүн шинжилгээ хийх	37
4.7. Аудитын илрүүлэлтэд хүрэх.....	38
4.8. ТХЗ-ын хэрэгжилтэд хийсэн аудитын зорилгын талаар дүгнэлт хийх	39
4.9. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын гүйцэтгэл	39
4.10. Аудитын үр өгөөж	40
V БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ.....	43
5.1. Аудитын зөвлөмжийг хэрхэн үр өгөөжтэй байдлаар боловсруулах вэ?.....	41
5.2. Хэрхэн иж бүрэн, үнэмшилтэй, ойлгомжтой, тэнцвэртэй агуулга бүхий аудитын тайланг хугацаанд нь бичих вэ?.....	42
5.3. Үндэсний зорилт биелэлтийн явцын талаархи аудитын тайланг түгээхдээ хэнийг ч орхигдуулахгүй байх.....	44
5.4. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнг тайлагнах	44
5.5. Аудитын үр өгөөж	45
VI БҮЛЭГ. АУДИТЫН МӨРӨӨР ХЯНАЛТ ТАВИХ, ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ҮР ӨГӨӨЖ	49
6.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөрөөр хяналт тавих	46
6.2. Гол асуудлыг харилцах	47
6.3. Талуудын хооронд холбоо тогтоох	47
6.4. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөрөөр тавих хяналтын тайлан	48
6.5. Аудитын үр өгөөж	48

ТОВЧЛОЛ

АДБ	Аудитын Дээд Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМХХ	АДБОУБ-ын Мэдлэг Хуваалцах Хороо
АХС	АДБОУБ Хөгжлийн Санаачилга
АТАЗ	АХС-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгын Аудитын Загвар
ДБ	Дэлхийн банк
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
ҮСДИ	Үндэсний Сайн Дүрын Илтгэл
ХЗЭЭҮХ	Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэл
ХЗЭЭҮХУ	Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгах

АХС-ЫН ТХЗ-ЫН АУДИТЫН ЗАГВАР (АТАЗ)-ЫН ТУХАЙ

Яагаад АТАЗ (ISAM) гэж?

НҮБ-ын гишүүн бүх улс орнууд 2015 оны 9 дүгээр сард Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (ТХЗ)-ыг хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. НҮБ-ын гишүүн орнуудын ТХЗ-ын талаархи тунхаглалд «Дэлхийгээ өөрчилье: Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр»-д “Улс орны Засгийн газрууд ирэх арван таван жилийн хугацаанд үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх арга зам, тэдгээрийг үнэлж дүгнэх үүрэг хүлээнэ» гэж тэмдэглэсэн.

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (АДБОУБ) нь НҮБ-ын 2030 Хөтөлбөрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, ТХЗ-ыг 2017-2022 оны Стратегийн төлөвлөгөөндөө 2 дугаар тэргүүлэх чиглэл болгон оруулсан. АДБОУБ нь гишүүн орнуудын аудитын дээд байгууллагууд (АДБ)-ыг «үндэсний тогтвортой хөгжлийн чиглэл, АДБ-уудын бүрэн эрхийн хүрээнд ТХЗ-ыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, тэдгээрийг үнэлж дүгнэхэд хувь нэмэр оруулахыг» уриалсан.

АДБОУБ болон АДБ-ын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхийн тулд АДБОУБ Хөгжлийн Санаачилга (АХС), АДБОУБ-ын Мэдлэг Хуваалцах Хороо (АМХХ) болон бусад түншүүд “ТХЗ-ын аудит гүйцэтгэх” санаачилгыг эхлүүлсэн. Энэхүү санаачилгын хүрээнд Африк, Ази, Карибын тэнгис, Европ, Латин Америк, Номхон далайн орнуудын 73 АДБ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын гүйцэтгэлийн аудитыг хийжээ. Эдгээр аудитын үр дүнг АХС-АМХХ-ны 2019 оны “Улс орнууд 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэлэн үү? АДБ-ын мэдэгдэл, зөвлөмжүүд” сэдвийн дор нийтэлсэн. Өнөөдрийг хүртэл хүрсэн үр дүнгээс үзэхэд, АДБ-ууд нь Засгийн Газарт хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлох, холбогдох арга хэмжээ авахад чиглүүлж, 2030 Хөтөлбөрийн үндэсний хэрэгжилтэд хараат бус хяналт тавьж, 2030 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлэн байдал болон хэрэгжүүлэлтийг сайжруулах тал дээр зөвлөмж өгч, 2030 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн ач холбогдлын талаар иргэд, оролцогч талуудын дунд мэдлэг, мэдээлэл тархахад хувь нэмэр оруулж ажиллажээ. Зарим тохиолдолд, АДБ нь Үндэсний Сайн Дурын Илтгэл (ҮСДИ)-ийг бэлтгэх ажилд зөвлөгөө өгч ажилласан байна.

Мөн, АДБ-ууд бэлэн байдлын аудитаас ТХЗ-ын хэрэгжилтийн аудит руу шилжих хүчтэй хүсэл зоригоо харуулсан. 2019 оны АДБОУБ конгресс (INCOSAI)-оор батлагдсан Москвагийн тунхаглалд “Төрийн аудитын цаашдын хандлага нь ТХЗ-той уялдсан үндэсний хэмжээний зорилтуудад хараат бус хөндлөнгийн хяналт тавих АДБОУБ болон АДБ-ын хүчтэй үүрэг амлалтаас хамаарна” гэдгийг мэдэгдсэн.

АДБОУБ болон АДБ-аас ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх хэрэгцээ их байгаа тул АХС нь АДБ-ын ТХЗ-ын хэрэгжилтэд хийх аудитыг үргэлжлүүлэн дэмжихээр шийдсэн. Энэхүү дэмжлэгийн эхлэл нь АТАЗ-ийг боловсруулсан явдал юм.

АТАЗ (ISAM) гэж юу вэ?

АТАЗ нь АДБ-уудыг ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой, Олон улсын Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт (АДБОУС)-д нийцсэн, «хэрхэн яаж хийх» практикт суурилсан заавар юм. Тус зааврыг дараах таван зарчимд үндэслэн боловсруулсан:

1. Үр дүнд төвлөрөх
2. АДБ-уудын олон талт байдалд уялдуулах
3. АДБОУС-д нийцүүлэх
4. Бүх талын оролцоог хангах
5. Үнэ цэн нэмэх

АТАЗ-т ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг **ТХЗ-ын зорилтод уялдсан үндэсний зорилтын хэрэгжилтэд чиглэсэн** гүйцэтгэлийн аудит гэж тодорхойлдог. Гүйцэтгэлийн аудит дотроо энэ нь аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөр, үйл явц дээр төвлөрдөггүй, харин үр дүнд хүрэхийн тулд тэдгээр хоорондын харилцаа, хамааралд анхаардаг. АТАЗ-д санал болгосон аудитын аргачлал нь АДБ-ыг зөвхөн үр дүнд анхаарах бус аудитын явцад **аудитын үр** өгөөж-ийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах сууриар хангадаг.

АДБ-уудын бүрэн эрх, чадавхи, хэмжээ, улс орны нөхцөл байдал нь олон талт байдал-ыг бий болгодгийг харгалзан үзэж, АТАЗ нь АДБОУБ-ын гишүүн АДБ-уудад зориулсан уян хатан загвар, практик зөвлөмж боловсруулсан.

АТАЗ-ын дагуу ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг өндөр чанартай гүйцэтгэхэд **АДБОУС**-ын холбогдох шаардлагыг дагаж мөрдөхийг шаарддаг. Энэхүү загвар нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх бүх үе шатанд АДБОУС-ын шаардлагыг хэрхэн баримтлах талаар зааварчилгаа өгдөг.

Чадавхи, чадамжаараа ялгаатай АДБ-уудын онцлогийг харгалзан үздэг тул энэ нь **бүх талын оролцоог хангасан** загвар болсон. Олон АДБ-уудын хувьд гүйцэтгэлийн аудитад АДБОУС хэрэгжүүлэх ажил нь хөгжүүлэлтийн шатандаа байгаа бөгөөд ихэнх АДБ-ууд Төрийн нэгдмэл бодлого зохицуулалттай байх (WoG) арга хандлагыг анх удаа ашиглаж байна. АТАЗ-д энэхүү хоёр нөхцөлийг харгалзан үзэж, дэлгэрэнгүй заавар боловсруулсан. Баримт бичиг, түүний агуулгыг боловсруулахдаа бид жендэрийн мэдрэмж, тэгш оролцоог хангахыг зорьсон. АТАЗ-д хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгах асуудлыг онцлох жишээ болгон оруулсан. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад “хэнийг ч орхигдуулахгүй байх” (LNOB) зарчмыг гол баримтлал болгодог.


АТАЗ-т баримтласан тав дахь зарчим нь **“үнэ цэн бүтээх”** зарчим юм. АТАЗ нь ТХЗ-ын зорилтод уялдуулсан үндэсний зорилтуудыг биелүүлэхэд чиглэдэг. Аудитын хамааралтай байдлыг хангахын тулд аудитын бүх үе шатанд гол оролцогч талуудтай уялдаа холбоотой ажиллахад анхаардаг. Аудитын мөрөөр тавих хяналтаас гадна, АТАЗ нь ТХЗ-ын хэрэгжилтэд хийсэн аудитаас өгсөн АДБ-ын зөвлөмжийн чанар, хүлээн зөвшөөрөлт, хэрэгжилтийг сайжруулах замаар аудитын үр өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар зааварчилгаа өгдөг.

АТАЗ хэнд зориулагдсан бэ?

АТАЗ нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудит-ыг анхлан гүйцэтгэх эсвэл аудитын арга зүйгээ сайжруулахаар төлөвлөж буй АДБ-ын менежерүүд болон аудиторуудад зориулагдсан болно. ТХЗ-ын тодорхойлолт, үндсэн ойлголт, аудитын үйл явцын бүлэг нь АДБ-ын удирдлагад ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын ажлыг удирдан, чиглүүлэх, стратегийн шийдвэр гаргахад туслах болно. Мөн АТАЗ нь АДБ-ын оролцогч тал, мэргэжлийн байгууллага, судалгаа шинжилгээ, иргэд олон нийтийн байгууллага, хөгжлийн түнш, ТХЗ-ын хэрэгжилтэд хөндлөнгийн хараат бус хяналтыг бэхжүүлэх чиглэлээр АДБ-тай хамтран ажиллаж буй олон улсын байгууллагын хэрэгцээнд ашиглагдаж болно.

АТАЗ-ыг хэрхэн ашиглах вэ?

АТАЗ нь 6-н бүлэгтэй. Эхний бүлэг нь “юу” гэсэн асуултад хариулна. Тус бүлэгт АХС нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг хэрхэн тодорхойлж буй тухай, ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад баримтлах гол зарчим, аудитыг хэрхэн АДБОУС-д нийцүүлэн гүйцэтгэх тухай ойлголтын сууриар хангана. Бүлэг 2-с 6 нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үе шат бүрийг “хэрхэн” гүйцэтгэх талаар зааврыг тусгасан.



Тус зааварт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг хэрхэн сонгох, төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах сэдвүүд хамаарна. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр өгөөж, аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, тайлагнах талаархи зааврыг мөн оруулсан болно. «Хэрхэн гүйцэтгэх вэ» зааварт бид ТХЗ-ын зорилт 5.2-тай уялдуулан хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгах үндэсний зорилтын аудитын жишээг ашигласан. Бүлэг бүрт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөн чанарыг аудитын үе шатуудад хэрхэн шингээж болохыг тайлбарласан.

Мөн АДБОУС-ын шаардлагыг дагаж мөрдөхөд туслах АДБОУС-ын шалгах хүснэгтийг тусгасан. Аудитын үйл явцтай холбоотой бүлгүүдэд «аудитаас гарах үр өгөөж»-ийг онцлон тэмдэглэсэн. Аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд АДБ-аас аудитын үе шат бүрт тавих ёстой асуултуудыг тэмдэглэв. Эдгээрээс гадна бид тус зааварт практик ач холбогдолтой зөвлөмж, зөвлөгөөг оруулахыг хичээсэн.

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад технологийн дэвшлийг ашиглах нь АДБ-ын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлнэ гэж бид үзсэн. Иймд АДБ-уудыг дэмжих зорилгоор бид ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад дата аналитикыг “хэрхэн” ашиглах талаар зааврыг Хавсралт 4-т багтаасан. Үүнээс гадна бүх талын

оролцоо (Хавсралт 1), аудитын төлөвлөлт (Хавсралт 2), аудитын мөрөөр тавих хяналт (Хавсралт 3)-тай холбоотой арга зүйн зааврыг хавсралтаар үзүүлсэн.

АТАЗ-ыг хэн боловсруулсан бэ?

Гүйцэтгэлийн аудит, ТХЗ-ын аудит, Хөтөлбөр 2030-ын хэрэгжилт, аудитад дата аналитикийг ашиглах чиглэлээр мэргэшсэн дадлага туршлагатай шинжээчдийн бүлэг АТАЗ-ын боловсруулалт болон хяналтыг гүйцэтгэсэн. Энэ хувилбарыг боловсруулахад багийн үндсэн гишүүдийн хувьд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж, АХС-ын багтай хамтран ажилласан Энэтхэг, Мальта, АНУ-ын АДБ, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар (UNDESA) -ийн мэргэжилтнүүдэд талархсанаа илэрхийлье. Мөн НҮБ-ын Төрийн удирдлагын шинжээчдийн хороо (UN CEPА), АДБОУБ Гүйцэтгэлийн аудитын дэд хороо, Бразилийн АДБ, Финландын АДБ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Олон улсын тогтвортой хөгжлийн хүрээлэн (IISD), НҮБ-ын Дотоод Хяналтын Алба (UN OIOS), НҮБ-ын Эмэгтэйчүүд байгууллага, Эмнести Интернэшнлийн мэргэжилтнүүдээс үнэтэй санал санаачилга ирүүлж хамтран ажилласныг онцлон тэмдэглэж байна.

АТАЗ-ын цаашдын чиг юу вэ?

АХС нь АТАЗ-ын энэхүү туршилтын хувилбарыг 2020 оны 3-р сард англи хэл дээр, 2020 оны 6-р сар гэхэд Араб, Франц, Испани хэл дээр нийтэлсэн. 2020-2021 онд бид хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг арилгах туршилтын аудитад энэхүү зааврыг мөрдөж ажиллахаар төлөвлөж байна. Мөн дата аналитик ашиглан төрийн тогтвортой худалдан авалтын аудит (Латин Америк ба Карибын тэнгисийн аудитын дээд байгууллагын кейс), ТХЗ-д уялдуулсан тодорхой үндэсний зорилтуудын хэрэгжилтийн аудитад тус зааврыг ашиглан хамтын (Араб ба Азийн АДБ) аудит гүйцэтгэнэ. АТАЗ нь шинэчлэгдэн найруулагдах нөхцөлтэй баримт бичиг юм. АХС нь гүйцэтгэсэн туршилтын аудит, хамтын аудит, хүлээн авсан санал хүсэлтэд үндэслэн АТАЗ-ыг шинэчлэнэ.

I БҮЛЭГ. **ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТ:** **Тодорхойлолт, гол зарчим, аудитын үйл явц**

АДБ-үүд ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлэн байдлын аудитаас ТХЗ-ын хэрэгжилтийн аудит руу шилжиж байгаатай холбоотой «ТХЗ-ын хэрэгжилтийн аудит гэж юу вэ?» гэх асуулт түгээмэл тавигдаж байна. Энэхүү бүлэгт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын талаарх АХС-ын байр суурийг илэрхийлэхийг зорьсон. Мөн гол зарчмууд, ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад баримтлах АДБОУС-д суурилсан аудитын үйл явцыг тайлбарлана.

Тодорхойлолт - ТХЗ-ын хэрэгжилтийн аудит

Нэг болон түүнээс дээш ТХЗ-ын зорилттой уялдуулсан үндэсний зорилтуудын биелэлтийг хангахад чиглэсэн багц бодлогын хэрэгжилтийн аудитыг хэлнэ. Аудит нь дараах зүйлст дүгнэлт гаргадаг: 1. Үндэсний зорилт биелэлтэд гарсан ахиц, 2. Одоогийн чиг хандлагаар зорилтууд цаашидаа биелэх магадлалтай эсэх, 3. Үндэсний зорилтууд нь ТХЗ-ын зорилтуудтай уялдаатай бөгөөд зохистой төлөвлөгдсөн эсэх ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага-ыг баримтлах шаардлагатай. Бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоотой байдалд дүгнэлт өгөхөөс гадна, аудитын зорилго, асуултуудыг дараах зүйлст дүгнэлт өгөх боломжтой байдлаар тодорхойлохыг эрмэлзэх шаардлагатай:

- *Хэнийг ч орхигдуулахгүй байх*
- *Олон талын хамтын ажиллагаа*

1.1. ТХЗ-ын зорилтод уялдсан үндэсний зорилт биелэлтэд гарсан ахицад аудит хийх

2030 Хөтөлбөр нь дэлхий нийтээр 2030 он хүртэл мөрдөх нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн хөгжлийн тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх тоон болон чанарын үзүүлэлт бүхий 17 ТХЗ-оос бүрддэг. Эдгээр 17 зорилго нь бүгд ижил ач холбогдолтой бөгөөд Тогтвортой хөгжлийн чиглэл хооронд аливаа

шатлал, эрэмбэ тогтоогоогүй. 17 зорилгод хамаарах 169 зорилтыг дэвшүүлсэн ба зорилтууд нь “үндэсний онцлог, хөгжлийн түвшинг харгалзан, үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлийг хүндэтгэн, дэлхийн шинж чанартай, бүх нийтээр ашиглах боломжтой” (Para. 55 A/Res/70/1) байдлаар тодорхойлогдсон. Засгийн газар бүр улс орны нөхцөл байдлаа харгалзан үндэсний зорилгоо тодорхойлж, ТХЗ-ын зорилтыг үндэсний бодлого, төлөвлөлт, стратегид хэрхэн тусгахаа шийднэ. 2030 Хөтөлбөрт хөгжлийн бодлого боловсруулалтыг тухайн улс орон өөрсдөө хариуцахыг онцлон тэмдэглэсэн. Улс үндэстэн бүр үндэсний тэргүүлэх чиглэлд суурилан үндэсний зорилтоо тодорхойлох шаардлагатай. ТХЗ-ыг нутагшуулан тодорхойлох нь нэн чухал асуудал юм. Иймд улс орон бүр тогтвортой хөгжилд хүрэхийн тулд өөр өөр хандлага, алсын хараатай байж болохыг хүлээн зөвшөөрсөн (Para. 59 A/70/1). Хөгжлийн түвшин нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг тул, улс орон бүр хамааралтай, бодитой зорилт тавихын тулд хөгжлийн зорилтыг нутагшуулах шаардлагатай.

ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлэн байдлын аудит хийсэн АДБ-ууд ТХЗ-ын зорилтыг үндэсний зорилттой уялдуулах үйл ажиллагаанд аудит хийсэн. АДБ-ууд аудитын бэлэн байдлаас аудитын хэрэгжилт рүү шилжиж байгаа энэ үед Хөгжлийн Хөтөлбөртэй уялдсан үндэсний зорилтуудад төвлөрч аудит хийхийг зөвлөж байна. ТХЗ нь олон зорилтыг хамарсан өргөн хүрээтэй тул аудитын хамрах хүрээг аудитлах боломжтой байдлаар төлөвлөж, сонгосон сэдвийг нарийвчлан судлах боломжоор хангахын тулд тухайлсан зорилтуудад анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Зорилго нь тогтвортой хөгжлийн бүхий л хүрээнд 16 сэдэвчилсэн чиглэлийг хамардаг бол Зорилго 17 нь хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэхтэй холбоотой тодорхойлогдсон. Зорилтууд нь сэдэвчилсэн байдлаар, жишээлбэл ТХЗ-ын Зорилт 3.1. эхийн эндэгдлийг бууруулах, эсвэл хэрэгжүүлэлтэд чиглэсэн, жишээлбэл ТХЗ-ын Зорилт 3d. урьдчилан сэрэмжлүүлэх, эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн эрсдэлийг удирдах чадавхийг бэхжүүлэх, байдлаар тодорхойлогдсон.

Үндэсний зорилтууд нь ТХЗ-ын зорилттой харьцуулахад хамрах хүрээ, нэр томъёогоор ялгагдаж болох боловч уялдаж буй ТХЗ-ын зорилтын хувьд хангалттай байх ёстой. Жишээ нь 12.7. Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжих зорилтыг Тогтвортой хөгжлийн гурван тулгуур (эдийн засаг, нийгэм, байгаль орчин)-ыг хамруулахгүйгээр тодорхойлбол энэ нь хангалттай байх зарчмыг биелүүлэхгүй. ТХЗ-ын Зорилт 4.1 нь бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд

үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байхад чиглэдэг. Хэрэв тухайн улсын үндэсний зорилт нь бүх хүүхдэд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага шатны боловсрол олгохоор хязгаарлагдвал энэ нь Зорилт 4.1-г тодорхой хэмжээнд агуулсан хэдий ч дунд шатны боловсролын асуудлыг хамруулахгүй учраас Зорилтын нөхцөлийг бүрэн хангахгүй.

Үндэсний зорилт нь ТХЗ-ын холбогдох зорилтоос ялгаатай байхын хэрээр ТХЗ-ын зорилттой уялдуулсан үндэсний зорилтын хангалттай байдлын талаар аудитын дүгнэлт өгөхийг зөвлөж байна. Үндэсний зорилтын хангалттай байдлын үнэлгээнд зорилтын цогц байдал, үндэсний нөхцөл байдалтай хамааралтай байдал, ТХЗ-ын зорилт ба үндэсний зорилтын хоорондох уялдааг хангах эрмэлзлийг хамруулж ойлгоно.

ТХЗ-ын Зорилт 3.3-тай холбоотой улс орны үндэсний зорилт нь ДОХ, сүрьеэгийн тархалт, гепатитын эсрэг тэмцэх, усаар дамжин халдварладаг өвчин, бусад халдварт өвчинтэй тэмцэх гэж тодорхойлсон жишээг авч үзье. Энэ тохиолдолд үндэсний зорилт нь ТХЗ-ын зорилт 3.3-д тусгайлан дурдсан хумхаа өвчнийг хамруулагүй байна. АДБ-аас тус улсад хумхаа өвчний тохиолдол ямар түвшинд байгааг үнэлж, ТХЗ-од тусгагдсан халдварт өвчний асуудлыг шийдвэрлэхэд үндэсний зорилт хангалттай эсэхэд тайлбар өгч болно. ТХЗ-ын зорилт 1.2-тэй холбоотой өөр нэг жишээг авч үзье. ТХЗ-ын зорилт 1.2 нь үндэсний тодорхойлолтын дагуу бүх хэмжигдэхүүнээр ядууралд амьдарч буй бүх насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эзлэх хувийг дор хаяж хоёр дахин бууруулах зорилготой юм. ТХЗ-ын 1.2-т уялдуулсан үндэсний зорилт нь энэ хувь хэмжээг 25% бууруулна гэж тодорхойлсон гэж үзье. ТХЗ-ын зорилтод тусгагдсаны дагуу дор хаяж 50%-иар бууруулах гэж заасныг харгалзан үзэж, энэ зорилт нь хангалттай амбицтай биш гэж АДБ-аас дүгнэж болно. Гэсэн хэдий ч үндэсний зорилтот түвшний хангалттай байдлыг үнэлэхийн тулд тухайн улс орны суурь түвшинг харгалзан үзэх ёстой бөгөөд асуудлыг шийдвэрлэх нөөц бололцоо, эдийн засгийн хүчин зүйл, түүнчлэн нөлөөлж буй соёлын, шашин шүтлэгийн, болон нийгмийн хэм хэмжээг харгалзан үзэх ёстой. Үндэсний нөхцөл байдлыг үнэлэснээр АДБ нь үндэсний зорилт нь улс орныхоо нөхцөл байдалд тохиромжтой бөгөөд биелэх боломжтой тодорхойлогдсон гэж дүгнэж болох ба энэ нь үндэслэлтэй хангалттай нотлох зүйл болно.

Улс орнууд ТХЗ-ын тодорхой зорилтыг шийдвэрлэхийн тулд өөр өөр үндэсний зорилт дэвшүүлж болно. Улс орнууд үндэсний зорилтоос хүрэх үр дүн, гарах үр дагаврыг ялгаатай байдлаар тодорхойлсноос хамааран АДБ-аас зорилт

биелэлтэд гарсан ахицыг хэмжих хэмжүүр ялгаатай түвшинд тодорхойлогдсон байж болно. ТХЗ-ын 5.2-р зорилтод уялдуулсан үндэсний зорилтууд нь жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, охидод үзүүлэх тусламж үйлчилгээний үндэсний стандартыг хэрэгжүүлэх, урьд нь цагдаагийн байгууллагаас үндэслэлгүй гэж ангилсан бэлгийн хүчирхийллийн хэрэг эсвэл гэр бүлийн хүчирхийлэл буурсан тухай мэдээллийг нягтлах ажлуудыг багтаасан байж болно.

Зарим улс ТХЗ-ын ихэнх зорилтыг шууд хэрэгжүүлэхээр шийдэж болох бөгөөд зарим улс үндэсний хэрэгцээнд тулгуурлан ТХЗ-ын зорилтыг баяжуулж болно. Ихэнх тохиолдолд улс орнууд үндэсний зорилгоо салбарын зорилттой уялдуулж байна. Улс орнууд тэргүүлэх чиглэлүүдийг өргөн хүрээтэй тодорхойлж, чиглэл бүрт үндэсний зорилтуудын багцыг баталж болно. АДБ-ын аудиторуд ТХЗ-ын зорилттой холбоотой үндэсний зорилтуудыг судлахдаа тухайн орны онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

Үндэсний зорилтод хүрэх нь урт хугацааны үйл явц учраас ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнд АДБ нь зорилтын биелэлтэд гарсан ахицад аудит хийж, төлөвлөсөн хугацаанд зорилтыг биелүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт өгч болно.

1.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага ашиглах нь

Үндэсний зорилт биелүүлэхэд Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага ашиглах шаардлагатай. Энэхүү хандлага нь засгийн газрын гүйцэтгэлийг аливаа хөтөлбөр, агентлагийн үйл ажиллагаанаас илүүтэйгээр нийгэмд тусламдаж буй асуудал, сорилтыг шийдвэрлэхэд гаргасан үр дүнд чиглүүлдэг. Энэ нь тогтвортой хөгжлийн сорилтуудын нарийн төвөгтэй байдал, нийгэм, эдийн засаг, байгаль орчны хэмжигдэхүүн хоорондын уялдаатай байдлаас үүдэн, үндэсний хэрэгцээ, тэргүүлэх чиглэлд нэгдмэл хариу арга хэмжээ авах зорилгоор яам, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулах шаардлагыг хангадаг. Ерөнхийдөө Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх гэдэг нь төрийн үйлчилгээ нэгдмэл бус байдаг асуудлыг шийдвэрлэн, нэгдмэл байдал, харилцан уялдаа, зохицуулалтыг сайжруулах суурь шийдэл юм. ТХЗ-ууд нь хоорондоо харилцан хамааралтай байдгаас үүдэн Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх хандлага нь ТХЗ-ын зорилтуудын хэрэгжилтийн аудитад зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай хандлага юм. Аудит нь үндэсний зорилтыг хэрэгжүүлэх үүрэгтэй яамд, төрийн байгууллагуудын санаачилга, тэдгээрийн харилцан уялдаа холбоо, хоорондын

хамтын ажиллагаа, зохицуулалт, харилцааны механизмыг харгалзан үзэж, засгийн газрын янз бүрийн түвшинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний цогц зураглалыг боловсруулах шаардлагатай. Энэ нь нэг эсвэл магадгүй цөөн хэдэн байгууллага, хөтөлбөр, үйлчилгээнд чиглэсэн гүйцэтгэлийн аудитаас ялгаатай. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад баримтлах төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага нь бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын сүлжээг бүхэлд нь хамруулан системийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг тодорхойлох боломжийг олгодог бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн үр дүнтэй хүргэхэд анхаардаг.

ТХЗ-ын зорилт 10.1-т заасны дагуу улс орны хамгийн ядуу иргэдийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотой үндэсний зорилтыг биелүүлэхэд чиглэсэн аудитад холбогдох яамд, түүний дотор нийгмийн халамж, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, алслагдсан бүсийн хөгжил, санхүү, эдийн засаг, эрүүл мэнд, гэр бүлийн асуудал хариуцсан яамдын хэрэгжүүлсэн арга хэмжээг хамруулна. Мөн бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт, сургалтын агентлагууд, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төрөл бүрийн агентлагууд, гэр бүл төлөвлөлтийн төвүүд, цагаачдад үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, нийгмийн судалгааны байгууллагууд зэрэг янз бүрийн байгууллагуудын хүчин чармайлтыг харгалзан үзэж болно. Түүгээр ч барахгүй аудиторуд эдгээр ялгаатай талууд хоорондын хамтын ажиллагаа, харилцаа хэрхэн өрнөж байгааг анхаарах шаардлагатай.

Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлагыг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг ядуусын хорооллын нөхцөлийг сайжруулах жишээгээр тайлбарлая. Их хотын ядуусын хорооллын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн аудит нь ядуусын бүх хорооллыг шинэчлэх төрийн оролцоог үр дүнгээ өгсөн гэж дүгнэж болно. Гэсэн хэдий ч шилжилт хөдөлгөөний улмаас ядуусын шинэ хороолол бий болж байгаа нь ядуусын хорооллыг арилгах ерөнхий зорилтыг алдагдуулна. Янз бүрийн яам, аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзэхдээ үүрэг, хариуцлага, чиг үүргийн уялдаагүй байдал, цоорхой, давхардал, давхцал зэргийг үнэлэх, зохих хяналт, зохицуулалтын механизм байгаа эсэхийг олж тогтоох нь чухал. Уялдаагүй байдал, давхцал, давхардлыг тодорхойлох АНУ-ын Засгийн Газрын Хариуцлагын Алба (GAO)-ын Үнэлгээ, удирдлагын гарын авлага нь энэ төрлийн шинжилгээнд хэрэгцээтэй мэдээлэл агуулсан байдаг. Түүнчлэн яам, аж ахуйн нэгжүүдэд үндэсний тэргүүлэх чиглэл, бодлого хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу биелүүлэхэд хуваарилагдсан төсөв нь зохистой эсэх, бодлого болон үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан эсэх, үндэсний зорилтод хүрэхийн тулд эдгээр яам, аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг юу болохыг үнэлэх нь чухал юм. Төсөвт хамаарах бусад асуудлын тухайд

төсөв нь хангалттай эсэх, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, санхүүгийн эх үүсвэрийг арвилан хэмнэлттэй зарцуулж байгаа эсэх зэрэг орно. Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх хандлагад анхаарах онцлог асуудлууд байдаг. Нэг асуудал нь Бодлогын уялдаа холбоог босоо болон хэвтээ тогтолцооны түвшинд авч үзэх асуудал юм. Хэвтээ тогтолцооны уялдаа холбоо гэдэг нь тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх нэгдсэн, тэнцвэртэй хандлага бөгөөд салбарын хэвшсэн үзлийг эвдэж, хамтын ажиллагаа, уялдааг дэмжих үзэл юм. Хэвтээ тогтолцооны уялдаа холбоо нь хөгжлийн тулгуур үзүүлэлтүүд, харьяалах салбаруудын харилцан хамааралтай байдлыг харгалзан үзэж, зөрчилдөх бодлогын чиглэлийг зохицуулах, харилцан нэгнээ дэмжих, бодлогын үр нөлөөг хамгийн их байлгахад анхаардаг. Босоо тогтолцооны уялдаа холбоо гэдэг нь хэрэгжүүлэлтэд бүс нутгийн, үндэсний болон дэлхийн асуудлуудыг анхаарч байгаа эсэхийг нягтлахад чиглэсэн засгийн газрын бүх түвшинд хамаарах уялдаатай байх хандлагыг хэлнэ.

Ихэнх үндэсний зорилтуудын хувьд янз бүрийн түвшний төрийн байгууллага бодлого боловсруулалт болон хэрэгжүүлэлтэд оролцдог. Зарим тохиолдолд бодлого, төсөв, хөтөлбөрийг төвлөрсөн түвшинд шийдэж, бүс нутагт хэрэгжүүлдэг. Энэ тохиолдолд ТХЗ-ын хэрэгжилтийн аудит нь засгийн газрын ялгаатай түвшинд үйл ажиллагаа явуулж буй төрөл бүрийн оролцогчдын хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хянаж, үнэлдэг. ТХЗ-ын зорилт 10.1-тэй уялдуулан улс орны хамгийн ядуу бүлгийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотой үндэсний зорилтод чиглэсэн аудит хийхдээ засгийн газрын янз бүрийн түвшний хүчин чармайлтыг авч үзэх шаардлагатай. Жишээлбэл, аудитын хүрээнд салбар яамдын тодорхойлсон ажил эрхлэлтийн бодлого, бүс нутгийн түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, зохион байгуулж буй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг үнэлж болно.

Үндэсний зорилт биелэлтийг хангах төрөл бүрийн үйлчилгээ, чиг үүрэг нь Засгийн газрын төв байгууллагаар дамжин хэрэгждэг байж болно. Үүнд стратегийн төлөвлөлт, бодлогын уялдаагаар хангах, мониторингт хяналт тавих, гүйцэтгэх удирдлагаар хангах, бодлогын чиглэл тодорхойлох, зохицуулалт хийх ажиллагаа гэх зэрэг үйлчилгээ, чиг үүрэг хамаарна. Засгийн газрын төв байгууллага эдгээр чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа эсэхээс хамааран төрийн байгууллагын болон нийт системийн үйл ажиллагааны үр дүнд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй тул аудитаар тухайн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шаардлагатай. Засгийн газрын төв байгууллага үр дүнтэй ажилласнаар манлайлал бий болж,

бодлогын нэгдмэл байдал сайжран, хэрэгжүүлэлт илүү үр дүнтэй болоход хувь нэмрээ оруулж чадна. Тиймээс ТХЗ-ын хэрэгжилтийн аудитаар холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэгч төв байгууллага байгаа эсэх, чиг үүргийн хамрах хүрээ, үйл ажиллагааны үр нөлөөг харгалзан үзэхийг зөвлөж байна.

Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгах (ХЗЭЭҮХУ) үндэсний зорилтод чиглэсэн аудит (ТХЗ-ын зорилт 5.2-д уялдуулсан) нь засгийн газраас ХЗЭЭҮХУ асуудлыг шийдвэрлэхэд хэвтээ тогтолцооны уялдаа холбоог хангахын тулд зохих институцийн зохицуулалтыг хийсэн эсэхийг авч үзэх шаардлагатай. Түүнчлэн, хэрэв тус улс Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэлтэй тэмцэхийн тулд тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгон тэгш байдлыг дэмжих зорилт тавьсан бөгөөд энэ зорилтын хүрээнд төрийн байгууллагын ажилтнуудын дунд мэдээлэл тархах сургалт, сурталчилгаа зохион байгуулж байгаа хэдий ч сургуулийн номонд уламжлалт жендэрийн үүргийг дүрсэлсэн хэвээр байвал хэвтээ тогтолцооны уялдаа холбоо хангагдахгүй байгааг илэрхийлнэ. Мөн, цагдаагийн байгууллагаас Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн дуудлагад онцгой анхаарал хандуулах, шуурхай хариу арга хэмжээ авах, арга хэмжээ авах хамгийн дээд хугацааг зааж өгөх үүргийг лавлах утасны дуудлагын системд нэвтрүүлсэн хэдий ч бүс нутгийн цагдаагийн хэлтсүүд энэ тухай мэдээллээр хангагдаагүй бол босоо уялдаа холбоо хангагдаагүйг харуулж байна.

Хэвтээ болон босоо тогтолцооны уялдааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2018 оны НҮБ -ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газрын Дэлхийн улсын секторын тайлангаас үзнэ үү.

1.3. Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим хэрэгжилтэд аудит хийх

Хэнийг ч орхигдуулахгүй байх нь 2030 хөтөлбөрийн гол зарчим юм. Хөтөлбөрийн хүрээнд ядуурал, тэгш бус байдалтай тэмцэх шаардлагатай байгааг ухамсарлаж, «хэнийг ч орхихгүй байх», “хамгийн ард үлдсэнд нь хамгийн түрүүнд туслах» шаардлагыг тогтоосон. Мөн ‘Бид энэхүү агуу хамтын аялалд гарахдаа хэнийг ч үлдээхгүй гэдгийг амлаж байна. Хүн бүр үнэ цэнтэй гэдгийг ухамсарлаж, бүх үндэстэн, ард түмэн, нийгмийн бүх давхаргад хүрэх зорилго, зорилтуудыг биелүүлэхийг бид хүсч байна. Бид эхлээд хамгийн алслагдсан цэгт хүрэхийг хичээх болно (4 -р зүйл)’.

Хэн ард хоцордог вэ? Хүмүүст хөгжлийн дэвшилд оролцох, үр шимийг нь хүртэх сонголт, боломж дутмаг үед ард хоцордог. Иймд туйлын ядууралд

амьдарч буй бүх хүмүүсийг «ард хоцорсон» гэж үзэж болох ба эмзэг нөхцөлд байдлаас үүдэн нийгмийн бусад хүмүүстэй харьцуулахад тэдний сонголт, боломж хязгаарлагддаг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2018 оны хэлэлцүүлгийн баримт бичигт хүмүүсийг ард хоцроход хүргэдэг таван гол хүчин зүйлийг тодорхойлсон.

- 1. Ялгаварлан гадуурхалт:** Хэн онцлог шинжээсээ хамааран гадуурхалт, зүй бус харилцаанд өртөж байна вэ? Үүнд: хүйс, үндэс угсаа, нас, нийгмийн давхарга, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, үндэс угсаа, уугуул иргэншил, суурьшил гэх мэт тодорхойлсон болон бусдын таамагласан шинжүүд.
- 2. Газарзүйн байршил:** Хэн оршин суугаа газраасаа шалтгаалан тусгаарлагдаж, төрийн үйлчилгээг хүртэж чадахгүй байх, тээвэр, интернэт болон дэд бүтцийн дутмагшилаас үүдэн эмзэг нөхцөлд байдалд амьдарч байна вэ?
- 3. Засаглал:** Хаана хүмүүс олон улсын, үндэсний болон орон нутгийн байгууллагуудын үр дүнгүй, шударга бус, хариуцлагагүй эсвэл хариу өгөхгүй байгаагаас болж хохирол амсдаг вэ? Хэн тэгш бус, зохистой бус, шударга бус хууль, бодлого, үйл явц, төсвийн хуваарилалтын гаж нөлөөг амсч байна вэ? Хэнд тэдний эрх ашигт нөлөөлөх шийдвэрт бодитой оролцох боломжоор хангагдахгүй байна бэ?
- 4. Нийгэм, эдийн засгийн байдал:** Хэн орлого, амьдралын түвшин, боловсролын тэгш бус байдлаас хохирч байна вэ? Хэнд эрүүл байх, шим тэжээл авах, боловсролтой болох боломж бага олдож байна вэ? Хэн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх боломжгүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжгүй, цэвэр ус, эрчим хүч, нийгмийн хамгаалалт, санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байна вэ?
- 5. Цочрол ба эмзэг байдал:** Хэн уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюул, хүчирхийлэл, зөрчилдөөн, нүүлгэн шилжүүлэлт, эрүүл мэндийн яаралтай нөхцөл байдал, эдийн засгийн хямрал, үнэ эсвэл бусад цочролын нөлөөнөөс болж уналтад өртөх магадлал өндөр байдаг вэ?.

Эдгээр хүчин зүйлт хамгийн их өртөж байгаа хүмүүс ялгаварлан гадуурхах үзэлтэй тулгарч, эмзэг байдалд байгаа нь тэднийг хамгийн хол орхигдох магадлалтай болгож байна.

ТХЗ-ын зорилтот үялдсан үндэсний зорилтуудад аудит хийхдээ АДБ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлахын тулд үндэсний засгийн газруудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлж болно.

Үүнд эмзэг бүлэгт хүртээх үр дүнг чухалчлах, түүнчлэн хүн амын дунджаас доогуур хэн, хаана амьдарч байгааг эрэлхийлж, тэдний онцлог хэрэгцээг тодорхойлох зэрэг болно. АДБ-ууд аудитын сэдвийг Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг харгалзан үзэж сонгох эсвэл үндэсний аль нэг зорилтод аудит хийхдээ Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлах боломжтой.

АДБ нь мөн дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай:

- Эмзэг бүлгийнхэн болон хамгийн ард хоцорсон хүмүүсийг хэрхэн тодорхойлж байна вэ?
- Хэн ард хоцорч байна вэ, тэдний эмзэг байдлын үндсэн шалтгаан юу вэ?
- Тэдний талаар мэдээллийн эх сурвалж байгаа эсэх, дутагдалтай байгаа мэдээлэл нь юу вэ?
- Эмзэг, хамгийн ард хоцорсон бүлгийн хэрэгцээг тодорхойлохын тулд ямар арга хэмжээ авч байна вэ?
- Эмзэг бүлгийн хүмүүсийг чадавхжуулах ажлыг дэмжихийн тулд юу хийж байна вэ?

Жишээлбэл, эхийн эндэгдлийг 50%-иар бууруулах үндэсний зорилтод чиглэсэн аудитад (ТХЗ -ын зорилт 3.1-тэй холбоотой) төрөхийн өмнөх тусламж үйлчилгээ нь уугуул иргэд, алслагдсан бүсэд амьдардаг эмэгтэйчүүд, өөр өөр үндэстэн, насныхан, хөгжлийн бэрхшээлтэй, цагаач эмэгтэйчүүдэд зориулсан тусгай зохицуулалт хийгдсэн эсэхийг үнэлж болно.

1.4. Олон талын хамтын ажиллагаанд аудит хийх нь

2030 Хөтөлбөрт баримтлаж буй гол зарчмуудын нэг нь хэрэгжүүлэх, дагаж мөрдөх бүх үйл явцад засгийн газрын бүх түвшин, салбар, иргэний нийгэм, хувийн хэвшил, парламентын гишүүд, хүний эрхийн үндэсний байгууллагуудыг оролцуулах, олон талын хамтын ажиллагааг хангах явдал юм. 2030 Хөтөлбөр нь тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлд онцгой анхаарч, зорилтуудыг хэрэгжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд оролцогч талуудыг хувь нэмэр өндөр ач холбогдолтойг ухамсарлахыг уриалдаг. Олон талын хамтын ажиллагаа, оролцоо нь тухайн шийдвэрт өртсөн бүлгүүдэд өөрсдийн хэрэгцээ, сонирхлыг илэрхийлэх, төрийн бодлогыг зохистой боловсруулах, хэрэгжүүлэх, хянахад засгийн газарт дэмжлэг үзүүлэх боломжийг олгох замаар үр дүнтэй шийдвэр гаргахад түлхэц болно. Оролцоо, зөвлөгөөн нь

оролцогч талуудад 2030 хөтөлбөрийг ойлгож мэдрэх боломжийг бүрдүүлж, улмаар ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд “олон нийтийн оролцоог хангасан цогц байх”-ад хувь нэмэр оруулдаг. 2030 Хөтөлбөр нь оролцогч талуудыг 2030 Хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлэн, хэрэгжүүлэлт, мониторинг, хянах явцад идэвхтэй оролцохыг уриалж байна.

Тогтвортой хөгжлийн зорилго нь өөр хоорондоо харилцан хамааралтай иж бүрэн цогц зорилго тул олон талуудыг оролцуулах нь асуудлын талаар илүү дэлгэрэнгүй, үнэн зөв ойлголт өгөх, бодлогын илүү оновчтой шийдлүүдийг тодорхойлох, хэрэгжүүлэлтийн талаархи санал хүсэлтийг авах замаар бодлогын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг сайжруулж чадна. Олон талуудыг урьдчилсан хэлэлцүүлэг, бодлого боловсруулалт, тодорхой үйлчилгээ үзүүлэхэд төр нийгмийн түншлэлийг бий болгох, мониторинг, хяналт, үнэлгээний үе шатуудад оролцуулж болно. Ядуурлыг бууруулах үндэсний зорилтод чиглэсэн аудитын ажилд олон талуудын оролцоог хангахад (ТХЗ-ын зорилт 1.2-той холбоотой) жишээлбэл хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай үед хуулийн төслүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх, шашны байгууллагууд болон ТББ-уудаас ядууст үзүүлдэг үйлчилгээний талаар мэдээлэл авах, эрдэмтдээс шаардлагатай арга хэмжээний талаар санал сонсох, ядуу хүмүүст чиглэсэн үйлчилгээний хэрэглэгчдийн дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулах зэрэг ажиллагааг зохион байгуулж болно.

АДБ-т олгогдсон бүрэн эрхээс хамааран «олон талын хамтын ажиллагаа»-нд чиглэсэн аудит нь гол төлөв ТХЗ-той уялдсан үндэсний зорилтыг тодорхойлох болон хэрэгжүүлэхэд олон талыг татан оролцуулах тал дээр засгийн газрын хүчин чармайлт байсан эсэхийг нягтлахад чиглэгддэг. Засгийн газар нь олон нийтийн хамтын ажиллагаа үүсэх зохих нөхцлийг бүрдүүлсэн эсэх, олон талын оролцооны цар хүрээ, голлох талуудын оролцоо, хамтын ажиллагаа нь зохистой байсан эсэхийг мөн аудитор шалгаж болно. Аудитаар хамтын ажиллагааны зохистой байдлыг авч үзэхдээ харилцаа холбооны сувгууд нь нээлттэй, шударгаар санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодог эсэх, санал хүсэлтийн систем нь оролцогч талуудад хүртээмжтэй, төвөгтэй биш байгаа эсэх, мөн санал хүсэлтийн систем нь олон удаагийн хэлэлцээр хийх боломжийг олгодог эсэхийг авч үзэж болно.

Жишээлбэл, хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгах үндэсний зорилтод чиглэсэн аудит хийх явцад (ТХЗ-ын зорилт 5.2-тэй холбоотой) олон тал гэдгээр салбарын яамд, аж ахуйн нэгж, хохирогч, хүчирхийлэгч, хохирогчийг хамгаалах бүлэг, хуулийн мэргэжилтнүүд,

шашны байгууллагууд, үндэсний статистикийн хороо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын агентлагууд, үйлчилгээ үзүүлэгчид, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил гэх мэтийг хамруулж болно. Хамтын ажиллагааны цар хүрээ хангалттай эсэхийг тодорхойлохдоо аудиторуд олон талын хамтын ажиллагаанд ямар механизм, платформ ашиглаж байгаа талаар авч үзэх, зөвлөгөөнд хамрагдсан талууд болон оролцоогүй гол оролцогч талуудыг тодорхойлох, оролцогчдын санал хүсэлтийг бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд хэрхэн, ямар түвшинд нэгтгэж байгааг үнэлэх, мөн ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн тулд байгуулсан түншлэлийг тодорхойлох ажлууд хийгдэж болно.

1.5. ТХЗ-ын хэрэгжилтийн аудит: АДБОУС-д нийцсэн, үр өгөөжид чиглэсэн гүйцэтгэлийн аудитын үйл явц

АДБ-уудад гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ын шаардлагуудыг ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг үр дүнтэй хэрэгжүүлэх аудитын аргачлалтай уялдуулахыг зөвлөж байна.



АДБОУС 300 ба АДБОУС 3000-ийн шаардлагыг хангасан аудитын үйл явц хэрэгжүүлэхийг зөвлөж байна. АДБОУС 300 нь ерөнхий зарчим, зарчмуудад хамаарах аудитын үйл явцыг тодорхойлдог. ТХЗ -ын хэрэгжилтэд аудит хийхдээ эдгээр хоёр зарчмыг анхаарч үзэх шаардлагатай.

Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-д нийцсэн аргачлалыг ашиглахдаа үр дүнд чиглэсэн болон тогтолцоонд чиглэсэн арга хандлагыг хослуулах нь энэ төрлийн аудитад хамгийн тохиромжтой байх болно.

Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ын шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна АДБ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэлтийн аудитаас гарах үр өгөөжийг урьдчилан тодорхойлох, аудитын бүх үе шатанд тодорхойлсон үр дүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээ авах, үүнд жишээлбэл олон талын хамтын ажиллагааг аудитын бүх үе шатанд хангах шаардлагатай.

Доорх зурагт ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ стандартын шаардлага болон аудитын үр өгөөж, ТХЗ-ын асуудлуудыг хамруулан хэрхэн гүйцэтгэх үйл явцыг дүрсэлсэн болно.

Дараах бүлгүүдэд АДБ нь ТХЗ-ын гол зарчмуудыг баримтлан, АДБОУС-д нийцүүлэн, аудитын үр өгөөжийг хангах байдлаар хэрхэн гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэх тухай заавраар хангах болно.

II БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН СУДЛАХ СЭДВИЙГ СОНГОХ

Эхний бүлэгт бид ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг тодорхойлж, аудиттай холбоотой гол ойлголтуудыг судлан, ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх АДБОУССтандартад нийцсэн аудитын үйл явцыг тодорхойлсон. Энэхүү бүлэгт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг сонгоход юуг анхаарах, тухайн асуудлууд яагаад чухал болох, АДБОУС-д нийцүүлэн хэрхэн аудитын сэдвийг сонгох талаар тайлбарлана.

2.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг сонгох: Юуг, яагаад?

ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгохдоо дараах гурван асуултад хариулах шаардлагатай.



Улс орон бүр хэд хэдэн үндэсний зорилтыг ТХЗ-той уялдуулан баталсан байдаг. Үндэсний нөхцөл байдлаа харгалзан засгийн газрууд хэрэгжүүлэх зорилтуудыг эрэмбэлэн, биелүүлэх хугацааг тодорхойлдог. Доорх хүснэгтээр ТХЗ 5: Жендэрийн тэгш байдлыг хангаж, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах зорилтыг үндэсний зорилттой хэрхэн уялдуулсаныг жишээгээр үзүүлэв.

Үндэсний зорилтууд	ТХЗ-ын зорилтууд
i. 2019 он гэхэд улс төр, удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг 30 хүртэл хувиар нэмэгдүүлэх;	5.2: Албан болон хувийн хүрээнд бүх эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэх, түүний дотор хүний хулгай наймаанд өртөх, бэлгийн болон бусад хэлбэрээр дарлах мөлжих явдлыг таслан зогсоох
ii. 2019 он гэхэд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хэмжих хяналтын тогтолцоог бий болгох;	
iii. 2020 он гэхэд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн хуваарилалтыг хянах механизмыг бий болгох;	

iv. Тусгай арга хэмжээнд үндэслэн эмэгтэйчүүдийг хууль сахиулах болон Нийгмийн Сүлжээний Шинжилгээнд оролцох оролцоог нэмэгдүүлэх	5.5: Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах
v. Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг 2021 он гэхэд 20% -иар бууруулах;	үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах
vi. 2022 он гэхэд эмэгтэй хүний бие эрхтэнийг хөндлөнгийн оролцоотой гэмтээсэн тохиолдлыг 70% -иас бага хэмжээнд хүртэл бууруулна	тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах

1-р бүлэгт дурдсанчлан үндэсний зорилтууд нь ТХЗ-ын сэдэвчилсэн зорилттой уялдаж болно. Жишээ нь: Зорилт 4.5 - 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш хүртээмжтэй эзэмших боломжоор хангах. Үндэсний зорилтуудыг ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай институцийг бэхжүүлэхэд чиглэсэн ТХЗ-ын зорилтуудтай холбож болно. ТХЗ-ын зорилт 16.6 - Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институцийг хэвшүүлэх. АДБ нь бүх үндэсний зорилтод нэгэн зэрэг аудит хийх боломжгүй тул үндэсний зорилтод дүн шинжилгээ хийж, тэдгээрийн ач холбогдол, хэрэгжүүлэхэд үүсэх эрсдэл, аудит хийх бололцоо, ТХЗ-ын хэрэгжүүлэлтэд аудитаас оруулах хувь нэмэр, үр өгөөжийг тодорхойлох шаардлагатай. АДБ нь зөвхөн үндэсний нөхцөл байдалд үндэслэх бус, АДБ-ын чадавхи, АДБ-ын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх ёстой.

2.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг хэрхэн сонгох вэ?

Энэ хэсэгт бид чадавхи болон нөхцөл байдлаараа ялгаатай АДБ-ууд ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг хэрхэн сонгох талаар тайлбарлах болно.

Сэдэв сонгоход баримтлах таван шалгуур - АДБ-д ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгохдоо зүүн талд үзүүлсэн таван шалгуурыг ашиглахыг санал болгож байна. Нэгдүгээрт, АДБ нь үндэсний зорилтын хүрээнд дэх шалгах зүйлд аудит хийх бүрэн эрхтэй эсэхийг авч үзнэ. Жишээлбэл, зарим АДБ-д улсын өрийн удирдлагад аудит хийх бүрэн эрх олгогдоогүй байж болно. Энэ тохиолдолд АДБ нь ТХЗ-ын зорилт 17.4-т аудит хийхгүй.



Үндэсний зорилтын ач холбогдол-ыг тухайн зорилтын үндэсний хөгжлийн асуудалд эзлэх байр суурь, зорилтыг биелүүлэхэд учрах эрсдэл, бусад зорилттой уялдаатай байдал, зорилтын бүс нутаг болон олон улсын тэргүүлэх чиглэлтэй уялдаатай байдал, зорилт биелүүлэхэд зарцуулах төсвийн хуваарилалт гэх мэтийг үнэлэн тодорхойлж болно. Ач холбогдлыг тодорхойлохдоо, АДБ нь Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг харгалзан үзэж, эмзэг бүлгийнхэнтэй холбоотой зорилтуудыг сонгоход онцгой анхаарч болно. Жишээлбэл, өнөөгийн Ковид-19 цар тахлын байдлыг харгалзан АДБ нь ТХЗ-ын зорилт 3.D Урьдчилан сэрэмжлүүлэх, эрсдэлийг бууруулах, олон улсын болон үндэсний эрүүл мэндийн эрсдэлийг удирдах зорилгоор, бүх улс орнууд, ялангуяа хөгжиж буй улс орнуудын чадавхыг бэхжүүлэх-тэй холбоотой үндэсний зорилтод аудит т хийхээр шийдэж болно. Үндэсний зорилтын аудит хийх боломжтой байдлыг үнэлэхдээ АДБ нь үндэсний зорилт хэрэгжилтийн үе шат, дата мэдээллийн бэлэн байдал, үндэсний зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлтийн бэлэн байдал, аудитын шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдал зэргийг харгалзан үзэж болно. Аудит хийх боломжтой байдлын шалгуурыг ашиглахдаа бүх дата мэдээлэл, шалгуур үзүүлэлт бэлэн болохыг хүлээхгүйгээр аудит хийхэд шаардлагатай хамгийн бага мэдээлэл, үзүүлэлт байгаа эсэхэд анхаарахыг зөвлөж байна.

Аудит хийх үндэсний зорилтыг сонгоход аудит хийх чадавхи-ийг харгалзан үзэх нь нэн чухал асуудал юм. ТХЗ-ын хэрэгжилтэд аудитыг өндөр чанартай

гүйцэтгэхийн тулд АДБ-д мэргэжлийн боловсон хүчин болон зохион байгуулалтын чадавхи хэрэгтэй. АДБ-д АДБОУС-д нийцсэн гүйцэтгэлийн аудит хийх, төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлагыг аудитад баримтлах, ТХЗ-ын хэрэгжилтийг уялдаа хамтын ажиллагаа, Хэнийг ч орхигдуулахгүй байх болон олон талын хамтын ажиллагаа зэргээр үнэлэх чадвартай мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй. Энэ төрлийн аудитыг гүйцэтгэхийн тулд АДБ нь аудит хийх тохиромжтой аргачлалтай байх шаардлагатай. Олон АДБ-үүд ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг шууд хийж эхлэж байгаа тул түршилтын аудит хийх, аудит хийх аргачлалдаа төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай арга хандлагыг нэвтрүүлэх тухай сургалт зохион байгуулах замаар чадавхижуулах ажлыг зохион байгуулж болно.

Аудитын сэдвийг сонгоход баримтлах хамгийн сүүлийн бөгөөд гол шалгуур нь үндэсний зорилт хэрэгжилтийн аудитын үр дүнд бий болох аудитын үр өгөөж юм. Сэдэв сонгох шатанд төлөвлөж буй үндэсний зорилт хэрэгжилтийн аудитын үр дүнд хүрэх үр өгөөжийг урьдчилан таамаглаж үзэхийг зөвлөж байна. Аудитын үр өгөөж гэдэг нь иргэд, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудын үр нөлөө, хариуцлага, хүртээмжтэй байдлыг сайжруулахад АДБ-ын гүйцэтгэсэн аудитын оруулсан хувь нэмэр юм. Аудитын үр өгөөжийн шалгуур нь аудит хийх үндэсний зорилтыг сонгоход АДБ-ын анхаарах гол асуудлуудын нэг болно. Жишээ нь: уур амьсгалын өөрчлөлт нь жижиг арлын орны оршин тогтнолд нь асар их нөлөө үзүүлж болзошгүй юм. Иймд тухайн улсын АДБ нь ТХЗ-ын зорилт 13-Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх арга хэмжээтэй уялдсан үндэсний зорилтуудад аудит хийхээр сонгож болно.

Өмнөх бүлэгт дурдсанчлан улс орнууд ТХЗ-ын зорилтуудыг үндэсний зорилттой уялдуулах олон янзын хэлбэр ашиглаж байна. Зарим тохиолдолд улс орнууд ТХЗ-ын зорилтыг үндэсний зорилт болгон сонгож, шууд хэрэгжүүлэх боломжтой байдаг бол бусад тохиолдолд улс орнууд бүс нутгийн тэргүүлэх чиглэлд үндэслэн үндэсний тэргүүлэх чиглэлүүдийг сонгож, дараа нь чиглэл түс бүрт хамаарах бүлэг зорилтыг тодорхойлж болно. Улс орнууд үндэсний онцлогоос хамаарч өөр олон зорилт дэвшүүлж болно. ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгохоос өмнө АДБ-ын аудитор үндэсний зорилтууд, тэдгээрийн ТХЗ-ын зорилттой уялдаатай байдлын талаар маш сайн ойлголтой болох нь чухал юм.

АДБ-үүд чадавхи, нөхцөл байдлын хувьд асар их ялгаатай байдаг тул дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн талаар мэдээлэл цуглуулахдаа өөр өөр

хандлага хэрэглэж болно. Томоохон АДБ-үүд мэдээлэл цуглуулах цогц системийг бий болгохыг илүүд үзэж магадгүй юм. Тэд мөн ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгохдоо тусгай маягт, сэдэв сонгох матрицыг ашиглахаар шийдэж болно. Зарим АДБ-үүд сэдэв сонгохдоо шалгуур бүрээр жинлэн, оноогоор үнэлж болно.

Практик зөвлөмж

АДБ нь үндэсний хөгжлийн төлөвлөгөө, ҮСДН-н тайлан, ТХЗ-ын зөрүүгийн шинжилгээ, зорилтын уялдааг хангах баримт бичиг, бэлэн байдлын аудитын баримт бичиг, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн шинжээчдийн бүлгийн боловруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн түвшний ангилал, тухайн улс дахь НҮБ-ын агентлагуудын мэдээлэл, олон талын нийтэлсэн мэдээлэл (жишээлбэл, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, бүс нутгийн байгууллагууд, хөгжлийн түншүүд гэх мэт) гэх мэт янз бүрийн эх сурвалжаас үндэсний зорилтуудын талаар мэдээлэл цуглуулж болно.

Чадавхи хязгаарлагдмал, жижиг АДБ-үүд илүү албан бус үйл явцыг ашиглан, баримт бичгийн түвшний шинжилгээ, уулзалт дээр үндэслэн эдгээр шийдвэрийг гаргаж болно. Хэдий АДБ-үүд сэдвийн сонголтод ялгаатай шийдэл ашигласан ч дээр дурдсан таван шалгуурыг харгалзан үзэж, сонгон шалгаруулах явц, хүрсэн шийдвэрээ баримтжуулах нь чухал юм. АДБ-үүд доорх хүснэгтийг ашиглан сонголт, шийдвэрээ баримтжуулж болно.

	Бүрэн эрх	Ач холбогдол	Аудит хийх боломжтой байдал	Аудит хийх чадавхи	Аудитын үр өгөөж
Үндэсний зорилт 1					
Үндэсний зорилт 2					



Үндэсний зорилт 3				
.....				
Үндэсний зорилт №				

Эдгээр шийдвэрийг гаргахад АДБ нь дотоод болон гадаад оролцогч талуудтай зөвлөлгөөн хийх шаардлагатай. Гадны оролцогч талуудтай хийх зөвлөлдөх уулзалт нь ярилцлагаас эхлээд илүү нарийвчилсан фокус бүлгийн хэлэлцүүлэг, олон талын хамтын ажиллагааг хамарч болно.

Дараагийн чухал асуудал нь **ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвийг АДБ нь гүйцэтгэлийн аудитын бусад сэдвүүдийн хамт сонгодог уу эсвэл тусад нь сонгодог уу?** гэдэгт хариулах явдал юм. Бидний санал болгож буйгаар АДБ нь гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгох нэгдсэн үйл явцтай байж болох бөгөөд үүнд ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдвүүд багтана. Ингэснээр гүйцэтгэлийн аудитын ажил, түүнд шаардагдах нөөцийг харгалзан үзэж үнэ цэн шингэсэн цогц арга хэмжээ авахад АДБ-д туслах болно.

ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх хэдэн сэдвийг сонгох вэ? ТХЗ-ын хэрэгжилтэд хийх аудитын сэдвийн сонголтоос гадна АДБ нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийн тоог шийдэх ёстой. АДБ-ын нөхцөл байдал, чадавхаас хамаарч нэг сэдвээс эхлүүлээд хэд хэдэн сэдвийг сонгож болно. Гүйцэтгэлийн аудитын чадавхи хязгаарлагдмал, орон тоо багатай АДБ-үүд ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх нэг сэдвийг сонгож болно. Ийм аудитыг олон улсын болон бүс нутгийн хамтарсан аудитын хэлбэрээр эсвэл экспертийн дэмжлэгтэйгээр АДБ-ын түвшинд туршилтын аудитаар гүйцэтгэж болно.

Салбар салбарын чиглэлийн аудиторүүдтай баг эсвэл аудитын газартай, төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлагын талаар ойлголттой мэргэжилтнүүд болон гүйцэтгэлийн аудитын чадавхи бүхий том эсвэл дунд хэмжээний АДБ-үүд ялгаатай салбаруудыг хамарсан үндэсний хэд хэдэн зорилтыг сонгож, аудит бүрийг олон талт багуудын нэгтгэн оролцуулах байдлаар гүйцэтгэж болно. Аудитын тусдаа газрууд ТХЗ-д үялдсан үндэсний зорилтод хамаарах нэг буюу түүнээс дээш аудитыг хийх зохицуулалттай байж болох бөгөөд эдгээр аудитыг хийхдээ холбогдох газрын аудиторүүдыг нэгтгэн олон төрлийн чадавхи бүхий баг бүрдүүлж болно. АДБ-ын бүрэн эрхээс хамаарч том АДБ нь олон салбарыг хамарсан, засгийн газрын янз бүрийн түвшинд (үндэсний, аймаг, орон нутгийн) аудит хийх чадавхи бүхий багийг бүрдүүлж болно.



Үндэсний зорилтод хэзээ аудит хийх вэ? Дээр дурдсанчлан, АДБ нь нэг үндэсний зорилтод аудит хийх эсвэл ТХЗ-ын хэрэгжилтэд олон жил дараалан аудит хийх төлөвлөгөө боловсруулж болно. АДБ хөндлөнгийн дэмжлэгтэйгээр аудит хийх тохиолдолд хамтарсан аудит эсвэл туршилтын аудит гүйцэтгэх дэмжлэг авах үедээ ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх шийдвэр гаргаж болно. Олон жил дамнасан аудит гүйцэтгэх чадавхитай АДБ нь үндэсний ТХЗ биелүүлэх стратегийн замын зураглалын дагуу зорилтод хүрэх хугацаа, зорилтын хамааралтай бөгөөд ил тод байдал, төлөвлөсөн ҮСДИ тайлан эсвэл сэдэвчилсэн тайлан, бүс нутгийн төлөвлөгөө, тэргүүлэх чиглэл, аудитын үр өгөөж гэх мэт хэд хэдэн асуудлуудыг харгалзан үзэж аудитын хугацааг тодорхойлж болно. Бид АДБ-уудад бололцооныхоо хэрээр ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвүүдийг олон жил дараалан аудит хийх байдлаар төлөвлөхийг зөвлөж байна. Ингэж багцлан гүйцэтгэх аудит нь дараахь давуу талыг бий болгодог:

1. Энэ нь засгийн газраас үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ, үйл ажиллагааны явцыг тодорхойлоход тусална.
2. АДБ нь аудит хийх чадавхидаа үндэслэн аудитыг зохих ёсоор төлөвлөж, бэлтгэл ажлыг хангах боломжтой.
3. АДБ-аас үндэсний зорилт биелэлтэд гарсан явцыг тогтмол давтамжтайгаар шалгахын тулд аудитын мөрөөр хяналт тавих аудит хийхээр төлөвлөх боломжтой болно.

Улс орны нөхцөл байдал, оролцогч талуудын хүлээлт нөхцөл байдлаас хамааран өөрчлөгддөг тул олон жил дараалан аудит хийхээр төлөвлөж буй АДБ-уудад бид төлөвлөгөөгөө жил бүр нягтлахыг зөвлөж байна. Сэдвийг

сонгохдоо гаргасан таамаглал хүчинтэй хэвээр байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Жил бүр хийх үнэлгээ нь АДБ-т шинээр үүссэн тэргүүлэх чиглэл/зорилтуудыг төлөвлөгөөнд оруулах боломжийг олгодог. Мөн АДБ-д жилийн аудитын төлөвлөгөөндөө багцын сэдвүүдийг оруулж, аудитын жилийн төлөвлөгөөний нэг хэсэг болгон аудит хийх хангалттай нөөц хуваарилахыг зөвлөж байна.

2.3. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын сэдэв сонгох

- ✓ Стратегийн сонгон шалгаруулалтын процесс дээр үндэслэн ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвүүдийг сонгосон уу?
- ✓ Аудитын сэдвийг ач холбогдол, аудит хийх боломжид үндэслэн, АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд сонгосон уу?
- ✓ Аудитын сэдвийг аудит хийх чадавхид үндэслэн аудитын үр өгөөжийг хамгийн их байхаар сонгосон уу?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгохдоо мэргэжлийн үнэлэмж ашигласан уу?
- ✓ Сэдэв сонгохдоо АДБ-ын ёс зүйн дүрэм, хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн үү?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг холбогдох оролцогч талуудтай харилцсаны үндсэнд сонгосон уу?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг сонгоход шаардлагатай үр чадвар АДБ-д бий юу?
- ✓ Сонгон шалгаруулалтад хангалттай хяналт тавьж ажилласан уу?
- ✓ Сэдэв сонгон шалгаруулалтын явцыг хангалттай баримтжуулсан уу?

2.4. Аудитын үр өгөөж

АДБ-ын аудитор аудитын сэдвийг сонгохдоо аудитын үр өгөөжтэй холбоотой дараах асуултуудыг тавьж болно.

- Аудитын сэдвийг сонгохдоо аудитын үр өгөөжийн шалгуурыг зохих ёсоор харгалзан үзсэн үү?
- Сонгосон аудитын сэдвүүд тус тусдаа болон хамтдаа ТХЗ-ын зорилттой уялдсан үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхэд ахиц гаргахад хувь нэмэр оруулах үү?
- Сонгон шалгаруулалтын үе шатанд аудитын үр өгөөжидд хүйс, хүртээмжтэй байдлыг харгалзан үзсэн үү?

III БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫГ ТӨЛӨВЛӨХ



Энэхүү бүлэгт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын хоёр дахь үе шатыг тайлбарлана. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын төлөвлөлтөд хийгдэх үйл явцыг тайлбарлаж, төлөвлөлт яагаад чухал болох, хэрхэн төлөвлөгөөг боловсруулах талаар заавраар хангана. Энэ явцаас гарах эцсийн бүтээгдэхүүн нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын баримтжуулсан төлөвлөгөө юм. Энэ бүлгээс эхлэн бид ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зааврыг жишээгээр баяжуулан тайлбарлана. Тус зааварт хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг устгахын тулд засгийн газрын хэрэгжүүлж буй арга хэмжээнд хийсэн аудитын жишээг ашиглана. Энэ нь төрийн үйлчилгээ болон хувийн харилцаанд эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэж буй хүчирхийллийн бүх хэлбэр (хүний наймаа, бэлгийн болон бусад төрлийн мөлжлөг гэх зэрэг)-ийг устгах зорилготой ТХЗ-ын зорилт 5.2-той холбоотой юм. НҮБ-ын 'Улбар шар Дэлхий' эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг арилгах кампанит ажлаас санаа авч бид "Улбар шар илэрхийлэл"-ийг ашиглав.

3.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх: Юу, яагаад?

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөхөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

- Үндэсний зорилтыг ойлгох
- ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ үр дүн болон тогтолцоонд чиглэсэн аудитын арга хандлагыг хослуулах
- Аудитын хамрах хүрээг аудит хийх боломжтой байдлаар тодорхойлох
- Үндэсний зорилтуудын хэрэгжилтийн явцыг үнэлэхэд анхаарах гол асуудлуудад үндэслэн аудитын зорилго, асуултыг боловсруулах
- Аудит хийхээр сонгосон үндэсний зорилтод хамаарах аудитын зохих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Засгийн газраас үндэсний зорилт биелүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг үнэлэх аудитын загварын матриц боловсруулах
- Аудитын төлөвлөгөөний баримт бичгийг эцэслэх

Аудитын загвар боловсруулалт нь шинэчлэгдэн засварлагддаг боломжтой үйл явц юм. Аудитын загвар нь аудитын дараагийн бүх үе шатыг тодорхойлдог тул ТХЗ-ыг хэрэгжүүлэх аудитын хамгийн чухал үе шат юм. Аудитын энэ үе шатанд аудитын баг хангалттай цаг зарцуулахыг зөвлөж байна.

3.2. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх: Үндэсний зорилтыг ойлгох нь

Үндэсний зорилтыг ойлгохын тулд аудитор бусад зорилттой ямар уялдаатай болохыг ойлгох; зорилт биелэлтийг дэмжиж буй хууль тогтоомж, байгууллага, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, үйл ажиллагаа, аж ахуйн нэгжийн талаар ойлголттой болох; үндэсний зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх гол оролцогч талуудын үүргийг ойлгож, зорилтод хүрэх явцыг хэмжих зохицуулалтуудыг ойлгох шаардлагатай. Аудитор хангалттай ойлголт олж авахад туслах асуултуудыг доорх жагсаалтаар үзүүлэв. **(эдгээр нь аудитын асуулт биш юм!)**

Институцийн болон хууль эрх зүйн орчин

1. Үндэсний зорилтот хамаарах хууль эрх зүйн болон институцийн тогтолцоо (бодлого, хөтөлбөр, олон улсын стандарт) нь юу вэ?
2. Үндэсний зорилтыг хэрэгжүүлэх ямар институцийн бүтэц бүрдүүлсэн байна вэ? Олон талууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
3. Аудитлагдаж буй зорилт болон бусад зорилго, зорилтуудын хооронд ямар чухал уялдаа холбоо байдаг вэ?
4. Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхийн тулд засгийн газрын янз бүрийн түвшний байгууллагууд (төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны) хэрхэн хамтран ажиллаж байна вэ?

Хэрэгжүүлэх арга зам

1. Зорилтыг биелүүлэхэд нөөцийн ямар хэлбэрүүдийг зарцуулахаар шийдсэн байна вэ?
2. Зорилтыг биелүүлэхэд төсөв, хүний нөөцийг хэрхэн хуваарилсан байна вэ?
3. Дотоодын нөөц боллоцоо, хөгжлийн албан ёсны тусламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гүйвүүлга гэх мэт нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг дайчлах талаар ямар арга хэмжээ авч байна вэ? Хэрэгжүүлэлтийг идэвхижүүлэхэд ямар түншлэл ашиглаж байна вэ?
4. Зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэн тусгайлан хуваарилсан алба/мэргэжилтнүүд байна уу?
5. Тэд зөвхөн энэ үүргийг биелүүлэхээр томилогдон ажиллаж байна уу, эсвэл давхар үүрэг, даалгавар гүйцэтгэдэг үү?
6. ТХЗ-ын зорилтыг хэрэгжүүлэхэд тус улсад тулгарч буй гол хүндрэл, бэрхшээл юу вэ?

Хяналт мониторинг, мөрөөр хяналт тавих

1. Үндэсний зорилтыг хэмжих үндэсний шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдал хангагдсан уу?
2. Үндэсний шалгуур үзүүлэлтүүд ТХЗ-ын үзүүлэлтүүдтэй нийцэж байна уу?
3. Шалгуур үзүүлэлтүүдийн суурь төвшинг тогтоож, ашиглаж байна уу?

4. Шалгуур үзүүлэлтийн явцыг хэмжихэд чиглэсэн мэдээлэл цуглуулах механизмууд нь юу вэ?
5. Шалгуур үзүүлэлтүүдийн талаар мэдээлэл цуглуулахад институцийн ямар бүтэц зохион байгуулалт, аргачлал ашигладаг вэ?
6. Шалгуур үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээллийн шинж чанарууд (задаргаа, эх сурвалж, хугацаа гэх мэт) нь юу вэ?

Олон талын хамтын ажиллагаа

1. Үндэсний зорилттой холбоотой институцийн зохицуулалт нь гол чиг үүргийн яамдууд, нутгийн захиргааны байгууллага, УИХ, хүний эрхийн байгууллагууд, ИНБ-ууд, хувийн хэвшлийг хэрхэн хамарч байна вэ?
2. Төрийн янз бүрийн түвшний байгууллага, УИХ, болон оролцогч талууд зорилт биелүүлэхийн тулд хэрхэн хамтран ажиллаж байна вэ?
3. Иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцогч талуудын зүгээс зорилтыг биелүүлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ гүйцэтгэхэд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн ямар механизм, платформ байдаг вэ?
4. Зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хувийн хэвшилтэй ямар түншлэл байгуулсан бэ?

Хэнийг ч орхигдуулахгүй байх

1. Үндэсний зорилтот хамаарах эмзэг бүлгийнхэн болон хамгийн ард байгаа хүмүүсийг хэрхэн тодорхойлдог вэ?
2. Бүх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хамгийн сайнаар хэрэгжүүлэн, хэнийг ч орхихгүй байхад анхаарч ямар арга хэмжээ хэрэгжүүлсэн бэ?
3. Эмзэг бүлгийнхний талаар мэдээлэл авах ямар эх сурвалж байдаг вэ?

Хэрэв бид дээрх асуултуудыг Улбар шар жишээнд ашиглавал асуултуудыг дараах байдлаар томъёолж болно:

1. ХЗЭЭҮХУ зорилт болон ТХЗ-ын бусад зорилтуудын хооронд ямар уялдаа байдаг вэ?
2. ХЗЭЭҮХУ зорилтод чиглэсэн үндэсний жендэрийн бодлого/үйл ажиллагааны төлөвлөгөө/стратеги байдаг уу?
3. ХЗЭЭҮХ-ийг зохицуулах хууль байдаг уу? Хууль нь хэр өргөн хүрээтэй вэ? Энэ нь ХЗЭЭҮХ-н чиглэлээр тусгайлан боловсруулагдсан хууль уу эсвэл бусад хууль тогтоомжид тусгагдсан зүйл заалтаар зохицуулагдсан уу?
4. ХЗЭЭҮХ-ийг устгах арга хэмжээнд төсөв хуваарилагдсан уу?
5. ХЗЭЭҮХУ-ыг хариуцах төрийн тусгай байгууллага бий юу?
6. Босоо болон хэвтээ тогтолцооны уялдаа холбоог хангах ямар механизм/ систем/ үйл явц/ процессууд байдаг вэ?
7. Суурь түвшин, шалгуур үзүүлэлтүүд бэлэн байна уу?

ХЗЭЭҮХУ-ын талаархи шинжээчдийн нийтлэлд ХЗЭЭҮХУ-д чиглэсэн бодлого, хөтөлбөр, санаачилгыг хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариуцлага хүлээлгэх гэсэн гурван тулгуурыг авч үзэх шаардлагатайг онцолсон. ХЗЭЭҮХУ-ад Урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариуцлага хүлээлгэх асуудлын талаар аудитор ойлголт олж авахад туслах зарим тодруулах асуултуудыг бид доор өгөв.

Урьдчилан сэргийлэх

1. Засгийн газар ХЗЭЭҮХ-ээс урьдчилан сэргийлэх хууль ёсны үүрэг хүлээдэг үү?
2. Урьдчилан сэргийлэх ажлыг ямар аж ахуйн нэгж/байгууллага хариуцдаг вэ?
3. Урьдчилан сэргийлэх ямар механизм хэрэгжиж вэ?
4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд эмзэг бүлгийн хүмүүсийг авч үзэж байна уу?
5. Засгийн газар нийгмийн бүх гишүүд, ялангуяа эрэгтэйчүүд, хөвгүүдийг ХЗЭЭҮХ-ээс урьдчилан сэргийлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулахыг уриалсан арга хэмжээ авсан уу?
6. Засгийн газар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бий болгоход хүргэдэг нийгэм, соёл, шашны зан үйлийг арилгах арга хэмжээ авсан уу?

7. Засгийн газар нь сургуулийн сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйд жендэрийн хэвшмэл буруу ойлголтыг арилгах чиглэлээр арга хэмжээ авсан уу?
8. Төрөөс эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр, үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээ авсан уу?
9. Төр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд технологи болон инновацийг хэрхэн ашиглаж байна вэ?

Хамгаалалт

1. Төр нь ХЗЭЭҮХ-ийн хохирогч болсон эмэгтэйчүүдийг хамгаалах хууль ёсны үүрэгтэй юу?
2. Хамгаалах ажлыг ямар аж ахуйн нэгж/аж ахуйн нэгж хариуцдаг вэ?
3. Хамгаалах ямар механизм хэрэгжиж байна вэ?
4. Эмзэг бүлгийн хүмүүсийг авч үзэж байна уу?

Хариуцлага хүлээлгэх

1. Засгийн газар ХЗЭЭҮХ-ийн хэрэгт холбогдсон гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэх хууль ёсны үүрэг хүлээдэг үү?
2. Хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг ямар байгууллага/аж ахуйн нэгж хариуцдаг вэ?
3. Хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчин бий юу?
4. ХЗЭЭҮХ-ийн хохирогчдыг мөрдөн байцаалт, шүүх ажиллагааны явцад тусгай хамгаалалтад авах механизм бий юу?
5. ХЗЭЭҮХ -ийн хохирогчдыг дэмжих/зөвлөгөө өгөх ажилд ИНБ-үүд хэрхэн оролцдог вэ?
6. Гэмт хэрэгтнүүдийг нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэхэд туслах хөтөлбөрүүд байдаг уу?

АДБ-ын аудитор олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулж дээрх асуултуудын хүрээнд ойлголт авах боломжтой. Эх сурвалжид: шалгагдагч байгууллагуудын баримт бичиг, судалгааны тайлан, холбогдох нийтлэл (жишээ нь эрдэм шинжилгээний өгүүлэл), НҮБ -ын агентлагуудын албан ёсны вэбсайт, ИНБ, эрдэм шинжилгээний байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, аудитын сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлууд орно. Бидний туршлагаас харахад орчин үед мэдээллийн олдоц арвин байдаг. Мэдээлэл цуглуулахдаа гол зүйлд анхаарахын тулд бид АДБ-ын аудиторыг тодорхой тооны гол оролцогч тал, мэргэжилтнүүдтэй ярилцахыг зөвлөж байна. Жишээ

нь: шалгагдагч байгууллагын албан тушаалтнууд, НҮБ-ын агентлагууд, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллагын мэргэжилтнүүд гэх мэт. Эдгээр оролцогч талууд нь аудиторт аудитын сэдвийн хүрээнд ерөнхий санааг олж харах, гол мэдээлэлд анхаарлаа чиглүүлэхэд тусалж чадна. Тэд мөн сэдвийн талаархи ойлголтыг өгч, хамааралтай, хэрэгтэй мэдээлэл олж авахад тусалж чадна.


ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх сэдвийг ойлгоход олон талын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Аудитор нь олон талтай харилцах хэд хэдэн аргыг ашиглаж болно. Үүнд ярилцлага, фокус бүлэг, олон талтай хийх уулзалт, яриа, судалгаа зэрэг багтана. Бид аудиторыг аудит хийж буй үндэсний зорилттой холбоотой төрийн болон төрийн бус оролцогчидтой хамтран ажиллахыг зөвлөж байна. Энэ үе шатанд холбогдох боломжтой оролцогч талууд нь зорилтыг хэрэгжүүлэх бодлогын чиглэлийн салбарын яамны ахлах менежерүүд, энэ сэдвээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаачид, бусад мэргэжилтнүүд, ИНБ-ын төлөөлөгчид, НҮБ-ын байгууллагууд болон Дэлхийн банк зэрэг бусад олон улсын агентлагуудын мэргэжилтнүүд байж болно.

Дээрх зааврыг Улбар шар илэрхийлэлд ашиглан, аудитор нь ХЗЭЭҮХУ зорилтыг хэрэгжүүлэх засгийн газрын арга хэмжээний талаар мэдээллийг дараахь байдлаар цуглуулж болно:

ХЗЭЭҮХУ зорилтыг хариуцсан төрийн байгууллагуудын хийсэн тайлан, үнэлгээ, олон улсын хэлэлцээр (жишээлбэл, НҮБ-ын конвенц)-ийн хүрээнд хийсэн үндэсний тайлантай танилцах; олон улсын конвенцууд, CEDAW, Belém do Pará, Maputo, Istanbul; АДБ-аас гүйцэтгэсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн аудит, эрдэм шинжилгээний нийтлэл, вэбсайтүүд, Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлийн СААФ, НҮБ-ын Эмэгтэйчүүд зэрэг ИНБ-үүдийн тайлан, ТХЗ-ын хэрэгжилтийн талаархи НҮБ-ын тайлан, НҮБ-ын ТХЗ Мэдлэгийн портал, IISD, ДБ-ны Жендерийн бүлэг, эдгээр байгууллагуудын твиттер болон цахим хаягт нийтлэгдсэн мэдээлэл. ХЗЭЭҮХ-тэй холбоотой урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариуцлага тооцох ажиллагааг хариуцдаг төрийн байгууллагуудын гол оролцогч талууд, НҮБ-ын агентлагууд, бусад олон улсын агентлагууд, ИНБ -ууд, хөгжлийн түншүүд, ХЗЭЭҮХУ чиглэлээр ажилладаг эрдэм шинжилгээний мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах.

ТХЗ-ын зорилго, зорилтууд хоорондоо уялдаатай байдаг. АДБ-ын аудитор нь аудит хийж буй зорилт болон ТХЗ-ын бусад зорилтуудын хоорондын уялдаа холбоог ойлгох нь шаардлагатай. Зорилтуудын хоорондох эерэг ба сөрөг уялдаа холбоог ойлгох нь хамтын ажиллагаанаас үүсэх эерэг үр дүн, харилцан учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлоход тусална. Харилцан учруулах сөрөг нөлөөллийг арилгаж, хамтын ажиллагаанаас гарах үр дүнг дээд зэргээр нэмэгдүүлэх нь ТХЗ-ын уялдаа, бодлогын нэгдмэл байдлыг хангах гол үзүүлэлт юм. АДБ-ын аудитор нь холбогдох тайлан, нийтлэлтэй танилцах, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, шинжээчид гэх мэт хүмүүстэй ярилцлага хийх, зөвлөлгөөн хийх замаар зорилтуудын харилцан уялдаа холбооны талаар ойлголт авах боломжтой. АДБ-ын аудитор нь ТХЗ-ын уялдааны шинжилгээ, дүрслэлийн загварыг ашиглаж болно. <https://sdginterlinkages.iges.jp/index.html>.

Аудит хийхээр сонгосон үндэсний зорилтын хүрээний хууль тогтоомж, институци, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, үйл ажиллагаа, аж ахуйн нэгжийн тогтолцоог ойлгох нь аудитын төлөвлөгөөний чухал хэсэг юм. АТАЗ-ыг хөгжүүлэх шинжээчдийн бүлгийн хуралдаан дээр НҮБ, АДБ-ын мэргэжилтнүүд аудитын сэдвүүдийн шинжилгээн дээр ажиллаж, сэдэвт хамаарах бодлогын бусад чиглэлүүдээс гадна системийн гол үйл явц, оролцогчдыг авч үзсэн. Үндэсний хууль эрх зүй, институци, бодлогын хүрээнд гарсан өөрчлөлтийг тусгаддаг тул холбогдох шинжилгээг улс орны тухайлсан нөхцөлд гүйцэтгэж болно. Ерөнхий шинжилгээ нь аж ахуйн нэгж, засгийн газрын түвшинд; мөн стратегийн болон бодлогын түвшинд хамаарах асуудлын төрлийг тодорхой харуулдаг.



Шинжээчдийн бүлгийн хуралдаан дээр мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар боловсруулсан төрийн тогтвортой худалдан авалтын ерөнхий шинжилгээний жишээг доорх зурагт үзүүлэв.

Зургийн дээд талд олон улсын болон үндэсний түвшний хууль тогтоомж, норм дүрэм журам болон хөгжлийн тусламжийг харуулсан болно. Олон улс оронд худалдан авалтын үйл ажиллагаа нь тодорхой хэмжээгээр хандивлагчдын тавьсан шаардлага, дүрмээр тодорхойлогддог. Иймд аудитыг хамааралтай байдлаар төлөвлөхөд тэдгээр шаардлагыг авч үзэх шаардлагатай. Үндэсний түвшинд, худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжоос гадна салбарын түвшний холбогдох хууль тогтоомжийг (жишээлбэл барилга, хөдөлмөрийн тухай) харуулсан. Нягтлан бодох бүртгэл, төсвийн зохицуулалт нь худалдан авалтын тогтвортой түршлагыг нэвтрүүлэх боломж, сэдэлжүүлэлтэд нөлөөлдөг тул анхааралдаа авах шаардлагатай ойлголт юм. «Худалдан авах ажиллагаа” гэсэн хайрцгийн дотор улс орны худалдан авалтын тогтолцоог гурван түвшинг ялган харуулсан. Доороос дээшлэх бүтцээр харбал, гурав дахь түвшин нь аж ахуй нэгж эсвэл хөтөлбөрийн түвшний асуудлыг илтгэнэ. Эдгээрт гэрээний менежмент; худалдан авах ажиллагааны ажилтнуудын чадавхи; төрийн тогтвортой худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын сэдэл; дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний систем; агентлаг болон бэлтгэн нийлүүлэгчийн хамтын ажиллагаа зэрэг орно. Хоёр дахь түвшин нь засгийн газарт хамааралтай асуудлыг жагсаасан бөгөөд зарим асуудал хувьд төвлөрсөн зохицуулалттай байдаг. Үүнд цахим худалдан авалтын платформ, амьдралын мөчлөгийн шинжилгээ, бүтээгдэхүүний каталог гэх мэт дэмжлэг үзүүлэх функцууд, мөн хамтарсан худалдан авалтын үйл ажиллагаа (жишээ нь төвлөрсөн худалдан авах нэгжүүд), төвлөрсөн удирдлага зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэх зэрэг орно. Үүнд мөн салбарын түвшний болон төрийн нэгдмэл бодлого, зохицуулалтын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, тогтвортой худалдан авалтын зорилт, хяналтын системийн асуудлууд багтсан. Нэг дүгээр түвшин нь засгийн газрын стратеги, амбицыг харуулна. Тогтвортой худалдан авалтыг үндэсний тогтвортой хөгжлийн стратегид тусгах, бусад холбогдох стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (жишээлбэл, инноваци эсвэл ЖДҮ-ийг хөгжүүлэх), төрийн худалдан авалттай холбоотой засгийн газрын зорилтууд, засгийн газрын хэрэгжүүлж буй механизм, арга хэрэгслүүд зэрэг бусад бодлогын зорилтыг дэмжих зорилгоор төрийн худалдан авалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн асуудлууд тусгагдсан. Энэ түвшинд төрийн удирдлагын бүтцийн өөрчлөлтийг илүү дэмжиж ажиллахын тулд засаг захиргааны соёлын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг хамруулж үздэг.

Гол оролцогч талуудын гүйцэтгэх үүргийг ойлгох нь аудит хийхээр сонгосон үндэсний зорилтын хэрэгжүүлэлтийг дэмжих тогтолцооны талаархи ойлголтын нэг хэсэг юм. Аудитын сэдэвтэй холбоотой үйл ажиллагаанд оролцож буй холбогдох оролцогч талууд, тэдний үүрэг, сонирхол, аудитын үр дүнд хүрэхэд хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлж, шинжилгээ хийх шаардлагатай. Бид үүнд оролцогч талуудын шинжилгээ болон RACI¹ шинжилгээ гэсэн хоёр хэрэгслийг санал болгож байна. Оролцогч талуудын шинжилгээг улбар шар жишээнд ашигласныг Хавсралт 2-оос үзнэ үү. Ингэхдээ ХЗЭЭҮХУ-тай холбоотой улс орны онцлог нөхцөл байдал, бодит байдлыг харгалзан үзэж, оролцогч талуудын шинжилгээг гүйцэтгэхийг зөвлөж байна.

Зорилтот хамаарах оролцогч тал бүрийн үүрэг, хариуцлага болон оролцогч талууд хоорондоо хэрхэн харилцаж, зохицож байгааг ойлгоход туслах хэрэгсэл нь RACI шинжилгээ юм. Энэхүү шинжилгээ нь гүйцэтгэлийг сааруулж, зорилтыг биелүүлэхэд саад учруулж болзошгүй үүрэг хариуцлагын давхцал, давхардал, эзгүйдэл ба зөрүүг илрүүлэхэд тусална. Холбогдох аж ахуй нэгжүүд нь оролцогч талуудын зураглалаар тодорхойлогдож болно.

Сонгосон зорилтын биелэлтийн явцыг хэмжих үндэсний зохицуулалтыг ойлгох нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад чухал ач холбогдолтой. АДБ-ын аудитор нь үндэсний зорилт биелэлтийн явцыг хэмжихэд ашигласан гүйцэтгэлийг хэмжих тогтолцоо, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд, хяналт-шинжилгээ, мөрөөр тавих хяналт болон үнэлгээг ойлгох ёстой. Мөн аудитор нь үндэсний зорилттой холбоотой дата мэдээллийн тогтолцоо, суурь түвшин, мэдээлэл цуглуулах систем, мэдээллийн задаргааны түвшинг ойлгох шаардлагатай.

¹ RACI шинжилгээ нь тухайн үйл ажиллагаатай холбоотойгоор оролцогч талуудыг дараах 4 үзүүлэлтээр шинжилдэг. Үүнд: Хэн тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бэ?, Хэн хариуцлага хүлээдэг вэ?, Үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө хэнтэй зөвлөх шаардлагатай вэ?, Хэрэгжилтийг хэнд мэдээлэх шаардлагатай вэ?

3.3. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад үр дүнд чиглэсэн болон тогтолцоонд чиглэсэн арга хандлагыг хослуулах нь

ТХЗ-ийн хэрэгжилтэд аудит хийхдээ үр дүн болон тогтолцоонд суурилсан аудитын арга хандлагыг хослуулан ашиглахыг зөвлөж байна. Үр дүнд чиглэсэн хандлага нь төлөвлөсөн гарц эсвэл үр дүнд хүрсэн эсэхийг үнэлэхэд тустай. ТХЗ-ын зорилттод уялдсан үндэсний зорилтууд нь хүрэх үр дүн бөгөөд ТХЗ-ын хэрэгжилтийн аудит нь үр дүнд хүрэх явцыг шалгадаг аудит юм. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлагыг ашиглан үндэсний зорилттод хувь нэмэр оруулж буй систем, түүний бүрдэл болох хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, аж ахуйн нэгжид шалгалт хийдэг. Тогтолцоонд чиглэсэн аудитын арга хандлага нь удирдлагын системийн зохистой ажиллагааг шалгадаг. Иймд тус хоёр хандлагыг хоёуланг нь хослуулах нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхэд тохиромжтой гэж үздэг.

3.4. Аудитын хамрах хүрээг аудит хийх боломжтой байдлаар тодорхойлох

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын хамрах хүрээг тодорхойлохдоо дөрвөн асуултанд хариулах шаардлагатай: **Юунд** аудит хийх вэ? **Хэнийг** хамруулж аудит хийх вэ? **Хаана**? **Ямар хугацааг хамрах вэ?**

“Юунд аудит хийх вэ” гэсэн асуултад ерөнхийдөө аудитор нэг буюу хэд хэдэн ТХЗ-тод уялдсан үндэсний зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулах бодлогын хэрэгжилтэд аудит хийнэ гэж хариулж болно. Гэсэн хэдий ч 2030 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн арга барил ашиглах шаардлагатай. Үндэсний зорилтууд нь хоорондоо уялдаатай бөгөөд зорилт тус бүр нь ихэвчлэн олон яам, төрийн байгууллага, засгийн газрын болон салбарын түвшний хариуцлагын асуудлыг хамардаг. Төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлага нь үндэсний хөгжлийн сорилт, тэргүүлэх чиглэлд нэгдсэн хариу арга хэмжээ авахын тулд төрөл бүрийн аж ахуйн нэгж, хөтөлбөрүүдийн хүчин чармайлтыг уялдуулах, нэгдсэн зохицуулалт байгаа эсэхийг шалгахыг зорьдог. ТХЗ-ын зорилтын түвшинд үр дүнд нөлөөлөх бодлого, институцийг ихэвчлэн илүү өргөн хүрээнд харах шаардлагатай. Аудитын явцад тулгарах сорилт нь аудитын хамрах хүрээг асуудалд нөлөөлж буй бодлогыг хамрахуйц хангалттай өргөн цар хүрээтэй байх («ярвигтай асуудал»-ыг хөндөхгүй орхихгүйн тулд) боловч аудит хийх боломжтой хэмжээнд хязгаарлах явдал юм. Аудиторын тухайн зорилтот хамаарах систем хэрхэн ажилладаг тухай болон хоорондын харилцан уялдаа холбооны тухай ойлголт нь аудитын хамрах хүрээг тодорхойлоход маш их тустай байх болно. Аудитор аудитын хамрах хүрээг аудит хийх боломжтой

байдлаар нарийсгах шаардлагатай хэдий ч хамрах хүрээг зөвхөн тухайлсан аж ахуйн нэгж, хөтөлбөрийн үндэсний зорилтод оруулсан хувь нэмрийг үнэлэх байдлаар хязгаарлахгүй.

Дээр дурдсанчлан, **хэнийг хамруулж аудит хийх вэ** гэдэгт хариулахын тулд аудитор нь оролцогч талуудын шинжилгээ, болон RACI-ийн шинжилгээнээс олж авсан ойлголтыг ашиглан хариултаа тодорхойлж болно. **Хаана аудит хийх вэ** гэдэг нь ихэвчлэн аудитын багийн чадавхи, нөөцөөс хамаарна. Боломжтой бол аудитор нь засгийн газрын янз бүрийн түвшин, улс орны өөр өөр бүс нутгийг төлөөлөх байршилд аудит хийхээр төлөвлөх шаардлагатай.

2030 Хөтөлбөрт улс орнууд ТХЗ-ыг үндэсний нөхцөл байдалд тохируулан нутагшуулах шаардлагатайг тодорхой илэрхийлсэн. Ихэнх тохиолдолд улс орнууд 2030 Хөтөлбөрийг батлахаас өмнө аудит хийхээр сонгосон ТХЗ-ын зорилттой холбоотой бодлогын зорилтуудыг баталсан байдаг. Тиймээс, аудитын хамрах хугацааг тодорхойлоход зарим зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Аудитын эхлэлийн шатанд аудитор дараахь асуудлуудыг анхаарч үзэж болно:

- Зорилго хэрэгжилтийн чиг хандлага, цугласан мэдээлэл, хийгдсэн бодлогын өөрчлөлт гэх мэтийг шинжлэх (жишээлбэл, энэ сэдвээр боловсруулсан бодлого, батлагдсан хууль тогтоомжийг судлах). Мөн тухайн асуудлын чиглэлээр хийгдсэн өмнөх тайлан, материалтай (АДБ эсвэл бусад байгууллагаас хийсэн) танилцах.
- Харьцуулах суурь болгон 2030 Хөтөлбөрийг батлахаас өмнөх тодорхой жилийг сонгох. Энэ нь аудиторт ТХЗ-ыг хэрэгжүүлж эхлээгүй хэдий ч мэдээлэл нь бэлэн, найдвартай, хамааралтай байх үетэй харьцуулах замаар хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх боломжийг олгоно.
- Урьд нь АДБ-аас тухайн сонгосон сэдвийн хүрээнд аудит хийж байсан эсэхийг харгалзан үзэж, өмнөх аудитын үр дүнг ашиглан суурь түвшинг тодорхойлж, асуудлын хүрээнд үнэлсэн давуу болон сул талд суурилан шинэ аудитыг хэрэгжүүлэх эхлэлийн цэгийг тодорхойлж болно.

Аудитын хамрах хугацааны эцсийн цэг нь аудитыг дуусгавар болгох хугацаатай аль болох ойр байх шаардлагатай.

3.5. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зорилгыг тодорхойлох

Аудитын зорилгыг тодорхойлох нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын төлөвлөлтийн гол цөм нь юм. Аудитор нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тодорхойлолт, сонгосон үндэсний зорилтын талаархи ойлголт, аудитын хамрах хүрээнд үндэслэн аудитын зорилтуудыг боловсруулдаг. Аудитор

нь аудитын нэг үндсэн зорилгыг тодорхойлж, тодорхойлсон нэг зорилтоо цааш хэд хэдэн аудитын асуулт, дэд асуултуудаар задлаж болно. Улбар шар жишээнд хамаарах аудитын гол зорилго нь:

Хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг арилгахад чиглэсэн засгийн газрын хүчин чармайлт болон хэрэгжилтэд гарсан ахиц дэвшлийг үнэлэх.

Бид АДБ-ын сонгосон үндэсний зорилт, үндэсний нөхцөл байдалд ашиглаж болох аудитын асуултуудын ерөнхий хүрээг тодорхойлох оролдлого хийсэн. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зорилгыг тодорхойлохдоо тухайн салбарын мэргэжилтнүүдээс мэдээлэл авахыг зөвлөж байна.

ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх аудитын асуултын хүрээ

1. Сонгосон үндэсний зорилгыг биелүүлэх чиглэлээр төрөөс хууль эрх зүй болон бодлогын тогтолцоо, институцийн зохицуулалтыг ямар түвшинд хангаж өгсөн бэ?

- 1.2. Засгийн газар хууль тогтоомж, бодлогын хүрээ, институцийн бүтцийг үндэсний хэмжээнд тохирсон зорилтод нийцүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авсан уу?
- 1.3. Зорилтод хамаарах хууль эрх зүй болон бодлого нь хөндлөн ба босоо тогтолцооны түвшинд уялдаатай (цоорхой, давхцал, давхардалгүй) байна уу?
- 1.4. Засгийн газар босоо болон хэвтээ тогтолцооны уялдаа холбоог бий болгох институцийн зохицуулалтыг хийсэн үү?
- 1.5. Хууль эрх зүй, бодлогын тогтолцоо, институцийн зохицуулалт нь зорилтод хамаарах эмзэг бүлгийн хэрэгцээг хангалттай хангаж чадаж байна уу?
- 1.6. Засгийн газар үндэсний зорилт биелэлтийг дэмжих хууль тогтоомж, бодлого боловсруулалт, төрийн тогтолцоог бүрдүүлэх үйл явц, институцийн зохицуулалтад иргэд, оролцогч талуудад (хууль тогтоох байгууллага, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил гэх мэт төрийн болон төрийн бус оролцогчдыг оролцуулан) мэдээлэл өгч, тэдний оролцоог хангасан үү?

2. Сонгосон үндэсний зорилтыг хэрэгжүүлэх чигэллээр Засгийн газар төлөвлөгөө болон төсвийг хэр хэмжээнд боловсруулсан бэ?

- 2.1. Засгийн газраас ялгаатай түвшинд баталсан төсөв нь уялдаатай, зорилтыг биелүүлэхэд хангалттай, бөгөөд зохистой байна уу?
- 2.2. Засгийн газар зорилтод чиглэсэн төлөвлөлт, төсвийг боловсруулж батлахдаа холбогдох бүх оролцогч талуудын оролцоог хангасан уу?
- 2.3. Засгийн газрын төлөвлөгөө, төсөв нь зорилтод хамаарах эмзэг бүлгийн тодорхой хэрэгцээг хангах асуудлыг хамруулсан уу?

3. Засгийн газар нь сонгосон үндэсний зорилтын биелэлтийг хангах арга хэмжээг хэр хэрэгжүүлсэн бэ?

- 3.1. Зорилтын биелэлтийг хангахын тулд янз бүрийн түвшний төрийн байгууллага, аж ахуй нэгжүүдийн хооронд үр дүнтэй зохицуулалт, хамтын ажиллагаа, харилцаа холбоо байна уу?
- 3.2. Засгийн газар сонгосон үндэсний зорилтыг биелүүлэхэд шаардлагатай нөөц бололцоог дайчилсан уу?
- 3.3. Зорилтын биелэлтийн хангахын тулд засгийн газар янз бүрийн түвшин, чиг үүргийн хүрээнд шаардлагатай чадавхийг бий болгосон уу?
- 3.4. Сонгосон үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд засгийн газар системийн эрсдэлийг тодорхойлж, шийдвэрлэсэн үү?
- 3.5. Сонгосон зорилтыг хэрэгжүүлэх засгийн газрын арга хэмжээ нь үр дүнтэй, хариуцлагатай, хүртээмжтэй байна уу?
 - а. Засгийн газар зорилтод хамаарах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүх талуудын оролцоог хангасан уу?
 - б. Эмзэг бүлгийн тодорхой хэрэгцээг хангах арга хэмжээг Засгийн газар хэрэгжүүлсэн үү?

4. Үндэсний хэмжээнд баталсан зорилт хэр биелсэн бэ?

- 4.1. Засгийн газар сонгосон үндэсний зорилтод хүрэх явцыг хэмжих, хянах, тайлагнах үр дүнтэй, ил тод, хүртээмжтэй системийг бий болгосон уу?
- 4.2. Засгийн газар сонгосон үндэсний зорилтод хүрэх төлөвлөгөөгөө

- 4.3. Одоогийн чиг хандлагыг харгалзан үзвэл засгийн газрын хүчин чармайлт нь төлөвлөсөн хугацааны дагуу сонгосон үндэсний зорилтыг биелүүлэхээр байна уу?

3.6. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад тохирох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох

Аудитын шалгуур үзүүлэлт нь үндэсний зорилтыг биелүүлэхэд засгийн газраас хэрэгжүүлж буй хүчин чармайлтыг үнэлэхээр аудиторын ашиглаж буй харьцуулах үзүүлэлт юм. Үндэсний зорилтыг ойлгох явцад цуглуулсан мэдээллийн тусламжтай ТХЗ-ын хэрэгжилтэд тавих аудитын шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Аудитын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо аудитор үндэсний гүйцэтгэлийг хэмжих тогтолцоо, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, олон улсын конвенц, гэрээ, үндэсний хууль тогтоомж, шилдэг туршлага гэх мэтийг ашиглаж болно.

Аудитын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохын тулд аудиторыг шалгагдагч байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвлөж байна. Олон байгууллага үндэсний зорилтын биелэлтийг хангахад оролцдог тул энэ нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхэд онцгой ач холбогдолтой байдаг. Энэ төрлийн аудитын сэдвийн шинэлэг байдлыг харгалзан үзвэл бэлэн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлт дутмаг байгаа юм. Шалгагдагч байгууллагуудтай санал бодлоо солилцох нь хамааралтай бөгөөд аудит хийх боломжтой байдлаар шалгуур үзүүлэлтийг тогтоох үр дүнтэй арга болно. Шалгагдагч байгууллагуудаас гадна төрөл бүрийн байгууллагын мэргэжилтнүүд шалгуур үзүүлэлт тогтооход баялаг эх сурвалж болж чаддаг. Шалгагдагч байгууллагуудтай хамтран ажиллах нь тустай боловч хэрэв шалгагдагч байгууллага аудиторын тогтоосон шалгуур үзүүлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол аудитор эцсийн шийдвэрийг гаргах бүрэх эрхтэй. Улбар шар жишээгээр үзүүлбэл:

ХЗЭЭҮХУ аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж
ХЗЭЭҮХУ олон улсын гэрээ, конвенцийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээс:

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)
- Belém do Pará конвенц
- Истанбулын конвенц 30

Бээжингийн тунхаглал, үйл ажиллагааны талбар (платформ)
Бразилийн Мария да Пенха хууль гэх мэт үндэсний хууль тогтоомж
Жендэрийн мэргэжилтнүүд

3.7. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад аудитын загварын матриц боловсруулах

Аудитын загварын матрицыг ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын төлөвлөлтийн шатанд хийсэн бүх ажлыг нэгтгэх хэрэгсэл болгон ашиглахыг зөвлөж байна. Ийм матриц нь ажлыг зохистой зохион байгуулж, бүтэцлэн, аудитын гүйцэтгэлийн үе шатыг дэмжихэд тусалдаг. Жишээлбэл, аудитын баг доор үзүүлсэн аудитын загварын матрицыг ашиглаж болно:

Аудитын сэдэв: _____						
Аудитын зорилго: _____						
Аудитын асуулт: _____						
Аудитын дэд асуулт: _____						
Шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр	Шаардлагатай мэдээлэл	Мэдээллийн эх үүсвэр	Дата цуглуулах үйл явц	Дата шинжилгээний үйл явц	Хязгаарлалт	Шинжилгээнээс бид юуг олж харах боломжтой вэ?

Энэхүү матриц нь аудитын асуултууд болон холбогдох шалгуур үзүүлэлтүүдээс гадна асуултуудад хариулахад шаардлагатай мэдээлэл, мэдээллийн эх сурвалжийг агуулдаг. Түүнчлэн дата мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх явцад хэрэгжүүлэх горимыг бүртгэх багануудыг агуулдаг. Аудитын загварын матриц нь гүйцэтгэлийн үе шатанд аудитын багт тулгарч болзошгүй хязгаарлалтыг ч мөн тусгадаг. Эцэст нь, аудитын загварын матрицад бүртгэгдсэн бүх мэдээллийг задлан шинжилсний үр дүнд гарч болзошгүй дүгнэлтийг эцсийн баганад тодорхойлдог. Хавсралт 3-т ХЗЭЭҮХУ-тай холбоотой нэг дэд асуултын аудитын загварын матрицын жишээг харуулсан.

3.8. Аудитын төлөвлөгөөг эцэслэх

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын төлөвлөлтийн төгсгөлд аудитын төлөвлөгөөг эцэслэх ажил хийгдэнэ. Аудитын төлөвлөгөөг эцэслэх ажлын явцад аудитын дараагийн үе шатуудыг дэмжих холбогдох бүх баримт бичиг, ажлын баримт бичгүүдийг нэгтгэнэ. Үүнд: Үндэсний зорилтын талаархи мэдээлэл, баримт бичиг; аудитын зорилго, асуулт, аудитын шалгуур, хамрах хүрээ; нотлох зүйл цуглуулах, дата анализ хийх, аудитын загварын матриц; багийн бүрэлдэхүүн, багийн үр чадварын үнэлгээ, шаардагдах нөөц, гадны шинжээчийн хэрэгцээ зэргийг багтаасан үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө; аудитын тооцоолсон зардал, ажлын үргэлжлэх хугацаа, үе шатууд, аудитын явцын хяналт тавих хэсгүүд зэрэг орно.

3.9. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөх

- ✓ Баг сонгосон үндэсний зорилтын талаарх ойлголтоо баримтжуулсан уу?
- ✓ Баг аудитын шалгуур үзүүлэлтийг шалгагдагч байгууллагатай ярилцсан уу?
- ✓ Баг нь төлөвлөлтийн үе шатанд шалгагдагч байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж, ажлын үр дүнг баримтжуулсан уу?
- ✓ Баг аудитын арга хандлага, хамрах хүрээ, зорилго, асуултуудыг тодорхойлохдоо аудитын зохих арга техникийг ашигласан уу?
- ✓ Баг нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг төлөвлөхдөө мэргэжлийн үнэлэмж ашигласан уу?
- ✓ Баг нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ АДБ-ын ёс зүйн дүрэм, хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн үү?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын төлөвлөгөөг боловсруулахад аудитын багт шаардлагатай үр чадвар байсан уу?
- ✓ Төлөвлөлт хийх явцыг зохих ёсоор хянаж байсан уу?
- ✓ Аудит хийхээр сонгосон үндэсний зорилт; аудитын зорилго, асуултуудыг тодорхойлоход ашигласан арга зүй; аудитын шалгуур үзүүлэлт; аудитын горим; аудитын загварын матриц; аудитын төлөвлөгөөтэй холбоотой зохих баримтжуулалт хийгдсэн үү?

3.10. Аудитын үр өгөөж

АДБ-ын аудитор аудитын төлөвлөлтийн шатанд аудитын үр өгөөжтэй холбоотой дараах асуултуудыг тавьж болно:

- Энэ аудитаас гарах үр өгөөж нь юу вэ?
- Тодорхойлсон аудитын хамрах хүрээний дагуу аудитаар төлөвлөсөн үр дүн гарах боломжтой юу?
- Тодорхойлсон аудитын зорилтын дагуу аудитаар төлөвлөсөн үр дүн гарах боломжтой юу?
- Энэхүү аудит нь ард хоцорсон хүмүүст эерэг нөлөө үзүүлэх үү?

IV БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТ

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын гүйцэтгэл аудитын төлөвлөгөөг баталснаар эхэлдэг. Энэ үе шатанд аудитор нь нотлох зүйл цуглуулж, нотлох зүйлд үнэлгээ хийж, аудитын илрүүлэлт болон дүгнэлтийг боловсруулж, бодлогын үялдаа холбоо, нэгдмэл байдал, олон талын хамтын ажиллагаа, Хэнийг ч орхигдуулахгүй байх, үндэсний зорилтыг биелүүлэх чиглэлийн бодлогын хэрэгжилттэй холбоотой аудитын зорилтуудын талаар аудитын горим хэрэгжүүлж, дүгнэлт хийдэг. Энэхүү бүлэгт дээр дурдсан ТХЗ-ын үндсэн асуудлуудад аудит гүйцэтгэх зарим гол асуудлуудыг тусгасан. Мөн энэ бүлэгт аудитор гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлдэг ялгаатай алхмуудад ашиглаж болох арга, техникийн талаар зааварчилгаа өгсөн болно.



4.1. Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд засгийн газрын үйл ажиллагааны үялдаа холбоо, нэгдмэл байдалд аудит хийх

Уялдаа холбоонд чиглэсэн аудитын асуултуудад хариулахын тулд аудитор нь өөр өөр бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудаас эхлээд сонгогдсон зорилтод хамаарах бодлого, институцийн тогтолцоог судалж үзэх шаардлагатай. Аудитаар бодлого хоорондын нийцэл, бодлогын зорилтод үзүүлэх нөлөөлөл, тодорхойлсон зорилттой нийцэж байгаа эсэхийг үнэлж болно. Аудитор нь янз бүрийн яам, агентлагууд үялдаатай байдлаар ажиллаж байгаа эсэхийг шалгах замаар засгийн газрын үр дүнтэй үйл ажиллагааг хэвтээ тогтолцооны үялдааны хувьд анхаарч үздэг.

Босоо тогтолцооны үялдаа холбоог үнэлэхдээ аудитор нь улс, бүс, орон нутгийн үйл ажиллагаанаас эхлэн иргэний нийгэм болон бусад гол оролцогч

талуудын үйл ажиллагааны үйлдээс холбоо хангагдаж байгаа эсэхийг нягтлах нь энэхүү шинжилгээний салшгүй хэсэг юм. Хэвтээ ба босоо тогтолцооны үйлдээс үнэлэхдээ аудитор нь үүргийн (үйлчилгээ, бодлого, институцийн бүтэц, хууль эрх зүйн тогтолцоо гэх мэт) давхцал, давхардал, эзгүйдлээс үүдэлтэй асуудлуудыг тодорхойлон, ангилан шинжилж болно. Энэ ч утгаараа аудитор нь бодлогын бүхий л сүлжээн дэх эрсдэлийг авч үзэн, үйлчилгээний үр нөлөө, үр дүнгийн биелэлт хангалттай эсэхийг тогтоох шаардлагатай. Ингэхдээ аудитор нь түхйлсан агентлагууд эрсдэлийг хэрхэн зохицуулж байгааг үнэлэх биш, харин зорилтыг биелүүлэхэд хамаарах бүхий л байгууллагуудын сүлжээ, үйл ажиллагааны хэв маягийн хувьд эдгээр байгууллагууд эрсдэлийг зохих ёсоор удирдаж байгаа эсэхийг үнэлэхэд оршино.

Эдгээр үйлдээс холбоог хангах үүрэг хариуцлага нь ихэвчлэн ахисан түвшний удирдлагын эрх хэмжээнд хамаардаг. Учир нь тэд ТХЗ-д уялдан үндэсний зорилт болон түүнээс хүрсэн үр дүн, гарцын хамаарлыг үзүүлсэн дата, бүртгэл, сайжруулах төлөвлөгөөний талаарх мэдээлэлд шууд хандах эрхтэй байдаг. Хэрэв тус үүргийн хуваарилалт тодорхой бус байвал энэ дутагдал нь өөрөө аудитын илрүүлэлт болдог. Аудитор үйлдээс холбооны талаарх асуултуудыг хэнээс асууж болохыг тодорхойлох ёстой.

ТХЗ-ыг хэрэгжүүлэхдээ улс орнууд ихэвчлэн засгийн газрын төв байгууллага, түхйлсэн агентлаг эсвэл үйлдээс хангах өөр зохицуулалтын механизмтай байдаг бөгөөд аудитор эдгээр асуултыг түхэйн байгууллагад шууд ханган асуух боломжтой. Аудитор нь зарим төрийн байгууллага үйлдээс хангах чиглэлээр бусдаас илүү ахиц дэвшил гаргаж байгааг илрүүлж болно. Үйлдээс хангах төв байгууллага байхгүй нөхцөл илэрвэл аудитор үйлдээс холбоог хангах ямар зохицуулалт байгааг олж мэдэх хэрэгтэй. Хэрэв ийм зохицуулалт байхгүй бол засгийн газрын үйл ажиллагааны үйлдээс хангах төв байхгүй байгаа нь тайлагнах үнэ цэнэтэй илрүүлэлт тул аудитын ажиллагааг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй байж болно. Дээрх нөхцөл байдлыг улбар шар жишээгээр үзүүлбэл:

Х улс ХЗЭЭҮХУ-тай холбоотой үндэсний зорилтоо биелүүлэхийн тулд засгийн газраас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариуцлага тооцох гэсэн гурван үндсэн чиглэлд анхаарлаа хандуулах шаардлагатай болсон. ХЗЭЭҮХ-ийг шийдвэрлэхийн тулд эдийн засгийн шалтгаан, нийгмийн тогтсон үзэл, аюулгүй байдлын асуудал, эмэгтэйчүүдийг хамгаалах хууль эрх зүйн орчин дутмаг байх, боловсролын дутмаг байдал, тус улсын шүүхийн тогтолцоо сул байх зэрэг бусад нөлөөлөгч хүчин зүйлсийг ч мөн зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Эдгээр бүх хүчин зүйлүүд нь нэг яамны үүрэг биш, харин хэд хэдэн оролцогч талуудын үүрэг хариуцлагад хамаарах тул зорилтод хүрэхийн тулд тэд хүчин чармайлтаа уялдуулах шаардлагатай.

Тодруулбал, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариуцлага тооцох чиг үүрэг нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, цагдаа, шударга ёсны салбартай холбоотой байдаг ба иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч мөн чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр чиг үүргийг жендэрийн тэгш байдал, боловсрол, шударга ёс, эрүүл мэнд, цагдаа, гэр бүлийн асуудал хариуцсан яамдтай холбож болно. Хэрэгжилтийн янз бүрийн чиглэлийг холбох хэвтээ тогтолцооны үйлдээс холбоо байх шаардлагатай. Үүний зэрэгцээ төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд улс, бүс, орон нутгийн байгууллагуудын хооронд босоо тогтолцооны үйлдээс хангагдах ёстой.

4.2. Үндэсний зорилтыг биелүүлэхэд олон талын хамтын ажиллагааг хангах тал дээр засгийн газрын гаргаж буй хүчин чармайлтад аудит хийх

ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн тулд 2030 Хөтөлбөрийн олон талын хамтын ажиллагааны зарчмуудыг улс орны бодлогын хөтөлбөрт тусгаж, иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад төрийн бус оролцогчидтой хамтран ажиллах хүчин чармайлтыг дэмжих шаардлагатай байна. Төлөвлөлтийн үе шатанд RACI-ийн шинжилгээг ашиглан аудитор нь оролцогч талуудын зураглал, зорилт биелэлтэд тэдний хүлээх үүрэг, хариуцлага, оролцогч талууд хоорондоо хэрхэн харилцаж, үйл ажиллагаагаа уялдуулж байгааг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн үе шатанд аудитор нь засгийн газар бусад оролцогч талуудыг зорилт биелүүлэхэд оролцох боломжоор хангах тал дээр ямар арга хэмжээ

авч хэрэгжүүлжц байгааг шалгах боломжтой. Анхааралдаа авах шаардлагатай өөр нэг асуудал нь тавьсан зорилтыг биелүүлэхэд байгууллагуудын тус тусын хил хязгаараас гадна хэрхэн институцийн уялдаа, хамтын ажиллагаа хангаж буй тухай асуудал юм. Аудитор нь гүйцэтгэлийг саармагжуулж, зорилго биелэлтийг хангахад саад болж болзошгүй давхцал, давхардал, орхигдолыг тогтоож болно.

4.3. Үндэсний зорилтыг биелүүлэхэд хэнийг ч орхихгүй байхын тулд засгийн газраас хэрэгжүүлж буй хүчин чармайлтад аудит хийх

Аудитын гүйцэтгэлийн явцад хэнийг ч орхихгүй байх зарчмыг авч үзэхдээ аудитор нь засгийн газрын арга хэмжээ нь бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтэд хойнохоцрох магадлалтай бүлгийг харгалзан үзсэн эсэх, тэдний төлөөллийн оролцоог дэмжиж, дуу хоолойг нь сонссон эсэх, мөн засгийн газрын хүчин чармайлаас харахад хэнийг орхихгүй байх зарчим баримтласан нь тодорхой харагдаж байсан эсэх талаар дүгнэлт хийхэд хангалттай зохистой нотлох зүйл цуглуулдаг. Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд хамгийн түрүүнд ард байгаа хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох, шийдвэрлэх талаар авч буй арга хэмжээний талаар мөн асуух шаардлагатай. Улбар шар жишээгээр үзүүлбэл:

Х улсад ХЗЭЭҮХ-ийн асуудлаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тэвчихгүй байх нийгмийн болон институцийн орчныг хөгжүүлэхийн тулд хүн ам зүйн янз бүрийн хэлбэр, нас, угсаатны бүлэг, уугуул иргэд, эдийн засгийн бүлэгт чиглэсэн санаачилга гарч болно. Аудитор нь олон төрлийн ялгаварлан гадуурхалтанд (уугуул эмэгтэйчүүд, охидын асуудал гэх мэт) өртсөн эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээ, эрхийг хамгаалах асуудлаар засгийн газраас үзүүлж буй хариу үйлдлийг үнэлэх шаардлагатай.

4.4 Үндэсний зорилтыг биелүүлэх чиглэлээр батлагдсан багц бодлогын хэрэгжилтэд аудит хийх

Салбарыг хамарсан зорилтыг биелүүлэхийн тулд засгийн газар бодлого болон стратеги боловсруулах замаар хэд хэдэн төрийн оролцоог бий болгодог. Эдгээр оролцоо нь бодлогод тусгагдсан үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэх ёстой. Хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийж төрийн оролцоонд дүн шинжилгээ хийх явцад аудитор нь тухайн хөтөлбөрийн түвшинд үнэлэхэд хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байна гэж үзэж болно. Гэсэн хэдий ч зорилт биелэлтийг хангахад чиглэсэн багц бодлогын хэмжээнд аудит хийх явцад ТХЗ-ын зарчмуудыг харгалзан үзэхэд тухайлсан нэгж хөтөлбөр нь зорилтыг

биелүүлэхэд хувь нэмэр оруулахгүй байгаа гэдгийг тогтоож болно. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд аудиторуд зорилтод хувь нэмэр оруулдаг багц бодлогын хэмжээнл аудитыг чиглүүлэх ёстой.

4.5. Үндэсний зорилтын биелэлтэд гарсан ахицын талаархи аудитын нотлох зүйл цуглуулах

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитор нь аудитын зорилго, дэд зорилт, аудитын асуултууд, гүйцэтгэлийг үнэлэх аудитын шалгуур үзүүлэлт, нотлох зүйлийн эх сурвалж, нотлох зүйл цуглуулах аргуудыг боловсруулсан. Аудитын нотлох зүйл цуглуулахдаа аудитор нь нотлох зүйл цуглуулахаар төлөвлөсөн аудитын горимыг хэрэгжүүлэх ёстой. Цуглуулсан аудитын нотлох зүйл нь холбогдох аудитын асуулттай хамааралтай, хангалттай бөгөөд найдвартай байх ёстой.

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын шинж чанарыг харгалзан аудитор янз бүрийн эх сурвалжаас аудитын нотлох зүйл цуглуулж болно. Аудитын сэдэвт хамаарах эх сурвалжид шалгагдагч байгууллага, үндэсний статистикийн байгууллага, судалгааны тайлан, холбогдох нийтлэлүүд (жишээ нь эрдэм шинжилгээний нийтлэлүүд), мэдээллийн сан, олон нийтийн мэдээллийн сан, НҮБ-ын агентлагуудын албан ёсны вебсайт, ИНБ-үүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, олон нийтийн мэдээллийн сүвгүүдээр нийтлэгдсэн мэдээлэл орно.

Зорилтод тохирох мэдээллийн эх сурвалжийг тодорхойлоход хэрэгтэй нэг зохистой эх сурвалж нь НҮБ-ын ТХЗ-ын талаархи цахим гарын авлага юм. Энэхүү эх сурвалж нь улс үндэстнүүдийн статистикийн системээс гаргаж авсан өгөгдөлд үндэслэн ТХЗ-ыг хэрэгжүүлэх явцыг хянахад туслаж болно. Хамгийн оновчтой нөхцөлд тухайн улс зорилт биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтийн эмхэтгэлийг хариуцах байгууллагыг оноосон бөгөөд тус байгууллага нь мэдээлэл цуглуулах, мэдээллийг боловсруулах, статистик тооцооллын аргачлалыг тодорхойлсон байж болно. Шалгуур үзүүлэлтэд үндэслэн бэлэн байгаа өгөгдлийг цуглуулахдаа аудитор нь тухайн сонгосон үндэсний зорилтод нийцсэн тохирох шалгуур үзүүлэлт мөн эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй. Улбар шар жишээгээр үзүүлбэл:

Нөхрийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлтэй холбоотой шалгуур үзүүлэлтэд хамаарах дата мэдээлэл нь ХЗЭЭҮХУ үндэсний зорилтыг хэмжихэд хангалттай биш юм. Учир нь энэ нь хамтрагчийн бусад хэлбэрт хамаарах хамтран амьдрагч, хамт амьдардаггүй одоогийн болон өмнөх хамтрагчийн хүчирхийллийн талаархи мэдээллийг оруулаагүй байна.

Аудитор нь мэдээлэл цуглуулах хэрэгсэл эсвэл үйл явцын хүчин төгөлдөр байдлыг анхаарч үзэх хэрэгтэй. Зарим тохиолдолд тухайн улс шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байж болох боловч шалгуур үзүүлэлтийн явцыг хянахад өгөгдөл цуглуулахад шаардлагатай механизмыг тодорхойлоогүй байх магадлалтай. Тухайн улс шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй тохиолдолд аудитор үүнийг аудитын илрүүлэлт гэж бүртгэж, холбогдох мэргэжилтэн, байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр эсвэл олон улсын түвшинд тогтоосон шалгуур үзүүлэлтийг харгалзан зохих шалгуур үзүүлэлтийг сонгоно. Аль ч хувилбарын хувьд аудитын үйл явцад өгөгдөл цуглуулах, одоо байгаа захиргааны бүртгэлээс мэдээлэл авах, эсвэл үндэсний статистикийн байгууллагад бэлэн байгаа өгөгдлийг тодорхойлох эсвэл шинжилгээ хийхэд тохиромжтой бусад хоёрдогч өгөгдлийг тодорхойлох ажил хийгдэнэ. Доорх жишээнүүдийг үзнэ үү:

Эхийн эндэгдэл	Зорилт 3.1	2030 он гэхэд дэлхийн эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд 70-аас бага хэмжээнд хүртэл бууруулна.
	Шалгуур үзүүлэлт 3.1.1	Эхийн эндэгдлийн харьцаа
	Мэдээллийн эх үүсвэр	Эхийн эндэгдлийг бууруулах үндэсний зорилтод чиглэсэн аудитын хувьд сонгосон үзүүлэлт нь эхийн эндэгдлийн коэффициент бөгөөд эмнэлгүүдийн эзэмшдэг захиргааны бүртгэл нь энэ харьцааг тодорхойлох нэг эх сурвалж байж болно. Хөгжиж буй орнуудад судалгааны мэдээлэл, ялангуяа Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа болон түүнтэй ижил төстэй өрхийн судалгаанаас авсан мэдээлэл нь эхийн эндэгдлийн талаархи хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалж болдог.
	Мэдээллийн задаргаа	Орлогын түвшин, оршин суугаа газар (хот/хөдөө), боловсролын түвшин, үндэс угсаа, хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагаа, асуудалтай бүс нутаг, дүрвэгсэд, түүнчлэн 15-19 насны өсвөр насныхан

Ядуурал	Зорилт 1.1	2030 он гэхэд бүх бүс нутагт байгаа одоогийн байдлаар өдөрт 1.25 доллараас бага орлоготой хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах
	Шалгуур үзүүлэлт 1.1.1	Олон улсын ядуурлын түвшнээс доогуур амьдралтай хүн амын эзлэх хувь, хүйс, нас, ажил эрхлэлтийн байдал, газарзүйн байршил (хот/хөдөө)
	Мэдээллийн эх үүсвэр	Хэт ядуурлыг арилгахад чиглэсэн аудитын хувьд ядуурлын түвшинг шалгуур үзүүлэлтээр сонгосон бол хүн амын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн орлого, зарлагын судалгааг ашиглан мэдээлэл цуглуулж болно.
	Мэдээллийн задаргаа	Өрхийн судалгааг өрхийн ядуурал, өрхийн гишүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, нас, ажил эрхлэлтийн байдал, газарзүйн байршлаар (хот/хөдөөгөөр) ангилах.

Аудитын явцад мэдээллийн үндсэн эх сурвалж байхгүй, сонгосон шалгуур үзүүлэлтүүдийн өгөгдлийн хүчин төгөлдөр байдал хангалтгүй тохиолдолд аудитор прокси өгөгдлийг ашиглаж болно. Прокси өгөгдөл нь зорилтыг ойролцоогоор хэмждэг. Доорх жишээг үзнэ үү.

Эхийн эндэгдэл	Шалгуур үзүүлэлт нь эхийн эндэгдлийн харьцаа юм. Анхдагч мэдээллийн эх сурвалж нь өрхийн судалгаа, эмнэлгийн бүртгэл юм. Эдгээр анхдагч мэдээлэл байхгүй үед аудитор нь мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар явагдсан төрөлтийн тоог Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаанд нийтлэгдсэн статистикаас авч ашиглаж болно.
----------------	--

Аудитор нь дата мэдээллийг аудитын нотлох зүйл болгон ашиглахдаа мэдээллийн үнэн зөв байдал, найдвартай байдал, хамрах хүрээ, бүрэн бүтэн байдал, цаг хугацаа зэрэг мэдээллийн чанарын асуудлыг авч үзэх шаардлагатай. Статистикийн агентлагуудын цуглуулж, нийтэлсэн мэдээлэл нь засгийн газрын талаархи мэдээллийн ихээхэн хэсгийг бүрдүүлдэг. Статистикийн агентлагуудын цуглуулдаг дата мэдээлэл нь тухайн агентлагийн үйл ажиллагааны зорилгоор бэлтгэгдсэн байдаг тул аудитор эдгээр мэдээллийг ашиглахаас өмнө аудитын зорилгод нийцэж байгаа эсэхийг үнэлж, баримтжуулж болно. Дата мэдээллийг аудитад ашиглахад тохиромжтой эсэхийг тодорхойлоход мэргэжлийн үнэлэмж ашиглах нь чухал юм.

Хэрэв цуглуулсан нотлох зүйлд аливаа хязгаарлалт, эргэлзээ байгаа бол аудитор дараахь зүйлийг хийх шаардлагатай:

- Бусад эх сурвалжаас хараат бус, баталгаатай нотлох баримт хайх;
- Асуудал дагуулж буй тодорхой нотлох зүйлийг хэрэглэхгүйн тулд аудитын асуулт эсвэл аудитын хамрах хүрээг дахин тодорхойлох;
- Аудитын илрүүлэлт, дүгнэлтийг хангалттай, зохистой нотлох зүйлд үндэслэн бэлтгэх;
- Дата мэдээллийн хязгаарлалт, эргэлзээтэй байдлыг илрүүлсэн холбогдох дотоод хяналтын томоохон сул талын хамтаар аудитын илрүүлэлтээр тайлагнах эсэхийг тодорхойлох.

Аудитор нь нотлох зүйл цуглуулахдаа янз бүрийн горим ашиглаж болно. Үүнд: ярилцлага, фокус бүлэг, судалгаа, баримт бичгийг судалгаа, ажиглалт, биет тест хийх. Тохиромжтой горимыг сонгохдоо аудитор уг горимын зохистой байдал, аудитын багийн чадавхи, шаардлагатай нөөцийг харгалзан үзэх шаардлагатай.

ХЗЭЭҮХ-ийн хувьд, дата мэдээлэл, нотлох зүйл цуглуулахдаа аудитын баг хохирогчид, тэр дундаа уугуул иргэд гэх мэт тодорхой эмзэг бүлгийн эмэгтэйчүүдтэй холбоо барьж болно. Нүүр тулан ярилцах нь хохирогчдоос мэдээлэл авахад тохиромжтой бус арга юм. Нөгөөтэйгүүр, асуулга судалгаа нь асуудлыг бүрэн хэмжээгээр нь илрүүлж чадахгүй байж болно. Янз бүрийн боломжит горимуудын давуу болон сул талыг авч үзсэний дараа аудитор дата мэдээлэл цуглуулах янз бүрийн аргуудыг хэрхэн зохистой ашиглах, болон түүвэрлэлтийн хэмжээг тодорхойлно.

ТХЗ гэх мэт нарийн төвөгтэй асуудлыг судлахад фокус бүлгүүд онцгой ач холбогдолтой байж болно. Фокус бүлгийн арга нь хүлээн авсан санал, сэтгэгдлийг харьцуулах замаар аудитын урьдчилсан илрүүлэлтийн зохистой эсэхийг нягтлахад туслана. Фокус бүлэгт аудитор нь талуудын оролцоотойгоор ярилцлага хийж, тухайн сэдвээр эсвэл аудитын асуудлаар тэдний үзэл бодол, түршлагын талаар мэдээлэл цуглуулж болно. Гэсэн хэдий ч шинжээчдийн санал аудитын илрүүлэлтийг шүүд илтгэхгүй, харин дараагийн шатанд баталгаажуулах зорилгоор ашиглах мэдээлэл юм. Улбар шар жишээгээр үзүүлбэл:

ХЗЭЭЗХХ-ийн үндэсний зорилтын фокус бүлэг нь бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжилтнүүдийг хамруулж болно (жишээ нь, цагдаа, нийгмийн үйлчилгээний ажилтнууд, сэтгэл зүйч, эмч, шүүгч гэх мэт).

Судалгаа хийх зөвлөмж

- Анкетыг хялбархан асуултуудаас эхлүүлээрэй
- Тодорхой, товч бөгөөд төвийг сахисан асуултуудыг бичээрэй
- Нэг асуултанд хоёр асуудлыг багтааж болохгүй
- Хоёрдмол утгатай асуултуудаас зайлсхий
- Шинжилгээнд ашиглах асуултуудыг асуу
- Хэт олон нээлттэй асуултуудаас зайлсхий
- Болж өгвөл зорилтот бүлгийн цөөн хэдэн гишүүдтэй судалгааны асуултуудын урьдчилсан тестийг хийх

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг хийхдээ аудитор илүү өргөн хүрээний оролцогч талуудаас нарийвчилсан, тодорхой мэдээлэл цуглуулах шаардлагатай үед судалгаа хийх нь үр дүнтэй арга байж болох юм. Зорилтын биелэлтийг хангахад оролцдог байгууллагын өөр өөр газар, хэлтсүүд эсвэл өөр өөр байгууллагуудыг судалгаанд хамруулах нь тохиромжтой байж болно.

Аудитор нь аудитын хугацаанд цуглуулах боломжтой бөгөөл шаардлагатай нотлох зүйлийн талаар бодит хүлээлт тавьж, хүн амын эмзэг хэсгийн төлөөллийг зохих ёсоор оруулж, төрөл бүрийн оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах, мөн зарим тохиолдолд түүврийн арга ашиглахыг зөвлөж байна.

4.6. Үндэсний зорилтын биелэлтийн явцын талаархи аудитын нотлох зүйлд дүн шинжилгээ хийх


Аудитын нотлох зүйлд дүн шинжилгээ хийх нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх гол алхам юм. Аудитор ийм шинжилгээ хийхдээ тоон болон чанарын янз бүрийн аргыг ашиглаж болно. Тоон шинжилгээний арга нь тоон мэдээлэл, статистик гэх мэт тоон өгөгдөлд дүн шинжилгээ хийх явдал юм. Эдгээр шинжилгээний аргууд нь дундаж эсвэл пропорцийг тооцоолохоос эхлээд илүү төвөгтэй статистик загварчлалаар гүйцэтгэгдэж болно. ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхэд тоон шинжилгээг ашигласнаар өгөгдлийн чухал хэв маяг, чиг хандлага, харилцааг илрүүлэхэд тусалдаг бөгөөд анхаарал хандуулах, сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлоход тусалдаг.

Чанарын шинжилгээ нь нотлох зүйлтэй холбоотой логик үндэслэл, аргументийг дэмжсэн мэдээллийг бүтэцжүүлэх, харьцуулах, эмхэтгэх, тайлбарлах өргөн хүрээний аргуудыг агуулдаг. Ихэвчлэн аудиторүүд ярилцлага, баримт бичиг, нээлттэй асуулгын асуултуудаас гарсан нотлох зүйлд чанарын дүн шинжилгээ хийдэг. Дата мэдээллийн хэв маяг, чиг хандлагыг илрүүлэхийн тулд статистик



шинжилгээг ашигладаг. Гүйцэтгэлийн зорилтын биелэлтэд дүн шинжилгээ хийх гэх мэт асуудлын шинжилгээнд мэдээллийг ойлгох, нэгтгэн дүгнэх, тархалтыг тайлбарлахын тулд ихэвчлэн дескриптив статистикийг ашигладаг. **Агуулгын шинжилгээ** нь нарийн төвөгтэй чанарын өгөгдлийг бүтэцлэн, дүн шинжилгээ хийж, тоон мэдээлэл болгон хувиргах арга юм. Зорилго нь дата мэдээллийг нэгтгэн дүгнэж болох цөөн тооны сэдэв эсвэл агуулгад хувиргаж, системтэйгээр ангилах, гол асуудалд төвлөрөх, хялбарчлах явдал юм. Агуулгын дүн шинжилгээ хийж болох чанарын өгөгдлийн жишээ нь: Яам, агентлагийн бодлогын баримт бичиг, ярилцлагын тэмдэглэл, сонин нийтлэл, фокус бүлгийн бичлэг, зарга нэхэмжлэлийн баримт, тайлан эсвэл нээлттэй судалгааны хариулт байж болно. Нээлттэй асуулгын хариулт гэх мэт нотлох зүйл болох боломжтой их хэмжээний түүхий өгөгдөл цугларсан бол агуулгын шинжилгээ ашиглах нь зохимжтой. Агуулгын шинжилгээг улбар шар жишээгээр үзүүлбэл:

ХЗЭЭҮХ-ийн аудитад хийсэн агуулгын шинжилгээ - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар авсан арга хэмжээ



Аудиторууд цагдаа, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр ажилладаг 340 хүний санал асуулгын хариуг цуглуулсан. Судалгааны эцсийн асуулт нь “Таны бодлоор манай улсад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, энэ төрлийн хүчирхийллийг бууруулахын тулд юу хийх ёстой вэ?” байсан.



Аудитын баг судалгааны хариултуудад агуулгын дүн шинжилгээ хийж, дараа нь хариултуудыг ангилав. Хамгийн түгээмэл зургаан ангиллыг диаграммын хэвтээ тэнхлэгт дурдсан болно. Үүнд: ажилчдын чадавхийг сайжруулах, ажилчдын тоог нэмэгдүүлэх, гэмт этгээдүүдтэй ажиллах, урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролыг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх.

4.7 Аудитын илрүүлэлтэд хүрэх

Аудитын илрүүлэлтэд хүрэх гэдэг нь «юу байх ёстой»-г «юу байна»-тай харьцуулан, үүссэн зөрүүгийн шалтгаан, үр дагаврыг тайлбарлах явдал юм. Аудитын илрүүлэлтийг боловсруулахдаа аудитор нь аудитын шалгуур үзүүлэлт нь юу байсан, ямар нотлох зүйл, түүний шинжилгээ хийсэн, ямар нөхцөл байдал илэрсэн, түүний шалтгаан, үр дагавар нь юу болохыг тодруулдаг. Энэхүү үнэлгээний дараагийн алхам нь аудитын зөвлөмж гаргахад хүргэж болзошгүй шалгуур үзүүлэлтээс зөрсөн шалтгааныг шинжлэн, түүний үр дагаврыг тодорхойлох явдал юм. Заримдаа, аудитын зорилт, асуултуудын талаар мэдээлэл дутмаг байгаа нь өөрөө аудитын зөвлөмж болдог. Жишээлбэл, аудитор нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зорилтот хэмжилтийн хувьд өгөгдлийн хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийн багц эсвэл нэгтгэсэн өгөгдөл дутагдаж байгааг илрүүлж болно.

<p>Шалгуур үзүүлэлт Бодит нөхцөл байдлыг харьцуулан хэмжих суурь - гүйцэтгэл эсвэл ердийн практик, уялдалаг эсвэл аудиторхоос тогтоосон стандартууд байж болно</p>	<p>Нотлох зүйлийн үнэлгээ Юут, яагаад шалтгаан - үнэлгээний цар хүрээ, хамрах хүрээ юу байсан</p>
<p>Илэрсэн нөхцөл байдал, суурь шалтгаан Нотлох зүйлийн эх сурвалж, цар хүрээг харуулах байдлаар нөхцөл байдал ямар байсан, түүний суурь шалтгааныг илтгэх</p>	<p>Үр нөлөө Аж ахуй нэгж бүрт үзүүлэх нөлөөллийг илэрхийлэн, аудитын илрүүлэлт нь юу байсанг илэрхийлж, яагаад чухал гэдгийг тайлбарлах</p>

Хэрэв шалгуур үзүүлэлт, нөхцөл байдлын үнэлгээ нь шалгуурыг хангаж эсвэл хүлээлтээс давсан бол энэ нь ч мөн нэг төрлийн аудитын илрүүлэлт юм.

Жишээлбэл, аудитор үндэсний зорилтын биелэлтийг хэмжих дата мэдээллийн тогтолцоо, шалгуур үзүүлэлт тодорхойлолт, мэдээллийн задаргаа дутмаг байгааг илрүүлж болно. Эсрэгээрээ шалгуур үзүүлэлт нь хүлээлтээс давсан буюу сайн гүйцэтгэлтэй байвал энэ нь мөн л аудитын илрүүлэлт юм. Аудитын илрүүлэлтэд хүрэхэд эерэг үзүүлэлтийг илтгэх нь чухал юм. Аудитор нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын илрүүлэлтийг томъёолж, баримтжуулахын тулд аудитын илрүүлэлтийн матрицыг ашиглаж болно. Доорх хүснэгтэд аудитын илрүүлэлтийн матрицын маягтын жишээг харуулав:

Нөхцөл байдал	Илрүүлэлт			Сайн туршлага	Зөвлөмж
	Шалгуур үзүүлэлт	Нотлох зүйлийн шинжилгээ	Шалтгаан		

Аудитын илрүүлэлтийн матрицын үлбар шар жишээг Хавсралт 3-т үзүүлсэн болно.

Аудитын илрүүлэлтийн матрицад үндэслэн аудитор аудитын илрүүлэлтийг боловсруулж эхэлдэг. Аудитын илрүүлэлтийг мэргэжлийн биш хүн ойлгох байдлаар энгийн үгээр илэрхийлэх нь чухал юм. Аудитор нь «үдшийн цайллага»-ын аргачлалыг ашиглан үдшийн цайллагад уригдсан төсөөллийн зочдод аудитын нотлох зүйлийг ойлгомжтойгоор илтгэх байдлаар хэд хэдэн мэдэгдэл боловсруулан, илэрхийлж болно.

4.8. ТХЗ-ын хэрэгжилтэд хийсэн аудитын зорилгын талаар дүгнэлт хийх

Аудитын зорилгын талаар дүгнэлт хийх нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх эцсийн алхам юм.

Тодорхойлолтын дагуу ТХЗ-ын хэрэгжилтийн аудитаар дараахь асуудлуудад дүгнэлт гаргадаг:

- үндэсний зорилтыг биелүүлэхэд гарсан ахиц дэвшил;
- өнөөгийн чиг хандлагад үндэслэн зорилгодоо хүрэх магадлал хэр өндөр байна;
- Үндэсний зорилт нь харгалзах ТХЗ-ын зорилтуудтай харьцуулахад зохистой байдлаар тодорхойлогдсон эсэх.
- Бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдсан эсэх, цаашид сайжруулах боломж
- Хэнийг ч орхихгүй байх;
- Олон талын хамтын ажиллагаа.

Практик зөвлөгөө

Аудитын дүгнэлтийг дараах байдлаар нягтлаарай:

- Хамгийн гол илрүүлэлт, сургамжийн талаар ойлгомжтой, товч ойлголт өгч чадаж байна уу?
- аудитын шалгуур үзүүлэлттэй уялдаж байна уу?
- Боломжтой хэмжээнд тоон илэрхийлэл ашигласан байна уу?
- Цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтийг тусгасан уу?
- аудитын илрүүлэлтийг тэнцвэртэй, шударгаар илэрхийлсэн үү?

Өмнөх бүлэгт тайлбарласан аудитын зорилго, зорилтууд, холбогдох аудитын асуулт болон дэд асуултуудын хүрээнд эдгээр дүгнэлтийн талаархи заавар боловсруулагдсан. Дүгнэлт нь мөн үндэсний зорилтод хамаарах хууль эрх зүй, бодлогын тогтолцоо, институцийн зохицуулалт, төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжүүлэлт, биелэлтийн явцыг хамруулж болно.

Аудитор нь зорилтод хамаарах шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болон аудитын явцад бэлэн боловсруулагдсан дата мэдээллийг харьцуулж, жилийн дундаж өөрчлөлтийг тооцоолох замаар зорилтод хүрэх магадлалын талаар дүгнэлт хийж болно. Энэ нь өөрчлөлтийн тогтмол хурдыг тооцоолох байдлаар таамаглал боловсруулах боломжийг олгодог. Хэрэв суурь түвшин болон аудитын жилийн хооронд хэд хэдэн өгөгдлийн цэг байгаа бол илүү нарийвчилсан хандлагын шинжилгээг хийх байдлаар таамаглалыг дэвшүүлж болно. Энэхүү шинжилгээнээс гадна засгийн газрын тогтолцоо, үйл ажиллагаа, зорилт биелэлтийг хангах болон биелэлтэд ТХЗ-ын зарчмуудыг баримтлах үүрэг, хариуцлагын хуваарилалттай холбоотой илрүүлэлт нь дүгнэлт, зөвлөмжийн нэг хэсэг болно.

Аудитын илрүүлэлтийн нэгэн адил аудитор тэнцвэртэй аудитын дүгнэлт бэлтгэхэд анхаарах шаардлагатай.

4.9. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын гүйцэтгэл

- ✓ Аудитын баг нь аудитын илрүүлэлтэд хүрэхдээ хангалттай, зохистой нотлох зүйл олж авсан уу?
- ✓ Аудитын дүгнэлт нь зорилт болон асуултуудтай уялдаатай бэлтгэгдсэн үү?
- ✓ АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд аудит зөвлөмж бэлтгэгдсэн үү?
- ✓ Аудитын баг цуглуулсан мэдээлэлд шинжилгээ хийж, аудитын илрүүлэлт нь аудитын зорилт болон асуултуудад хариулсан эсэхийг баталгаажуулсан уу?
- ✓ Шаардлагатай тохиолдолд аудитын зорилго, зорилт болон асуултуудыг шинэчлэн боловсруулсан байна уу?
- ✓ Аудитын баг аудитын явцад шалгагдагч байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж, ажлын үр дүнг баримтжуулсан үү?
- ✓ Тус баг ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ мэргэжлийн үнэлэмж ашигласан үү?
- ✓ Тус баг нь ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ АДБ-ын ёс зүйн дүрэм, хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн үү?
- ✓ Тус багт ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх шаардлагатай үр чадвартай байсан үү?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх явцад багийг зохих ёсоор хянаж байсан үү?
- ✓ Аудитын нотлох зүйл цуглуулах, аудитын нотлох зүйлийг шинжлэх, аудитын илрүүлэлт болон дүгнэлтийг боловсруулахтай холбоотой баримтжуулалтыг зохистой боловсруулсан байна уу?

4.10. Аудитын үр өгөөж

АДБ-ын аудитор аудит хийхдээ үр өгөөжтэй холбоотой дараах асуултуудыг тавьж болно:

- Аудитын дүгнэлт нь аудитын үр өгөөжийг хүргэх үү?
- Энэ үе шатанд олон талын оролцоог хангах нь аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд туслах үү?
- Аудитын дүгнэлт нь сонгосон үндэсний зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эмзэг бүлгийн хүмүүсийн үзэл бодол, статусыг хангалттай тусгасан үү?

V БҮЛЭГ. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

Өмнөх бүлэгт бид ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зорилго, зорилтуудын талаар дүгнэлт хийсэн. Энэ бүлэгт бид аудитын үр дүнг хэрхэн тайлагнах талаар авч үзэх болно. Тайлагнах үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэдэг:



5.1. Аудитын зөвлөмжийг хэрхэн үр өгөөжтэй байдлаар боловсруулах вэ?

АДБ бүрэн эрхийнхээ хүрээнд аудитын явцад илрүүлсэн сул тал, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах байдлаар аудитын зөвлөмжийг боловсруулна. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зөвлөмж боловсруулахдаа АДБ-ын аудитор дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

- зөвлөмжүүд нь хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага руу хэт халдахгүй байх
- илэрсэн дутагдлын суурь шалтгааныг авч үзэх
- зөвлөмжийг хэнд зориулсан, юуг тусгайлан санал болгож байгааг тодорхой илэрхийлэх

Зарим АДБ-ууд аудитын илрүүлэлтийг боловсруулах явцдаа аудитын зөвлөмжийг боловсруулдаг.

Аудитын зөвлөмж боловсруулахад АДБ-ын аудиторуудад өгөх дараах практик зөвлөмжүүдийг бэлтгэлээ:

Аудитын зөвлөмж боловсруулах практик зөвлөмжүүд	ТХЗ-ын тайлан, нийтлэлтэй танилцах. Жишээ нь Үндэсний Сайн дурын Илтгэлийн тайлан нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх сайн туршлагыг харуулдаг
	Мэргэжилтнүүд, оролцогч талууд болон шалгагдагч байгууллагуудтай зөвлөлдөх
	Зөвлөмж хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц болон тэргүүлэх чиглэлийг анхаарах
	Үндэсний нөхцөл байдлыг анхаарах
	SMART (тодорхой, цаг үеэ олсон, хэрэгжүүлэх боломжтой, хамааралтай, цаг хугацаатай) зөвлөмж бичих

Жишээ:

АДБ-аас хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй төвүүдийг цагдаа, шүүхийн байгууллагаас гадна эмнэлгийн байгууллага, иргэд нийгэм, төрийн бус байгууллагуудаар нэмэгдүүлэн, хоорондын уялдааг хангаж ажиллахыг зөвлөж байна.

5.2. Хэрхэн иж бүрэн, үнэмшилтэй, ойлгомжтой, тэнцвэртэй агуулга бүхий аудитын тайланг хугацаанд нь бичих вэ?

АДБ-ын аудитор нь аудитын дүгнэлтэд аудитын бүх гол зорилтуудад хамаарах асуудлуудыг багтаасан эсэхийг нягтлах замаар аудитын **иж бүрэн** тайлан бичиж болно. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын гол асуудлуудад дараах зүйлс хамаарах ба дүгнэлт нь тэдгээртэй уялдах шаардлагатай:


- үндэсний зорилтуудыг биелүүлэхээр боловсруулсан багц бодлогыг хэрэгжүүлэх засгийн газрын үйл ажиллагааны хэвтээ ба босоо тогтолцооны уялдаа, түүний цар хүрээ;
- үндэсний зорилт биелэлтэд гарсан ахиц, одоогийн нөхцлөөр тодорхойлсон зорилтод хүрэх магадлал, үндэсний зорилт нь ТХЗ-ын зорилттой хэр зохистой уялдуулсан болох;
- Засгийн газар үндэсний зорилтоо хэрэгжүүлэхэд “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг ямар түвшинд хэрэгжүүлсэн болох;
- үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд олон талын хамтын ажиллагааг хэрхэн хангасан тухай

Үнэмшилтэй аудитын тайлан нь логик бүтэцтэй бөгөөд аудитын зорилго, шалгуур үзүүлэлт, илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжийн хоорондын уялдааг

тодорхой илэрхийлж, улмаар холбогдох бүх аргументыг тусгадаг. ТХЗ-ыг хэрэгжүүлэх талаар олон тооны материал нийтлэгдсэн. АДБ-ын ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тайлан нь хангалттай зохистой нотлох зүйлд үндэслэн, аудитын дүгнэлтэд хүрэх үйл явц, нөхцөл байдлыг хараат бус хөндлөнгийн өнцгөөс илтгэж буйгаараа бусад нийтлэгдсэн ажлуудаас ялгардаг.

ТХЗ-ын аудитын тайланг **цаг тухайд** нь хүргэснээр удирдлага, засгийн газар, хууль тогтоох байгууллагын мэргэжилтнүүд болон бусад сонирхогч талуудад тайланд тусгагдсан мэдээлэлд үндэслэн үр нөлөөтэй арга хэмжээ авах боломжийг олгодог. АДБ тайлан нийтлэх хугацааг тогтоохдоо хэд хэдэн нөхцөл байдлыг харгалзан үзэж болно. Үүнд: АДБ нь тайланд тусгагдсан үндэсний зорилтын талаар хангалттай мэдээлэл ил болсон үед тайлангаа нийтлэхээр шийдвэрлэж болно. АДБ нь тухайн улсын Үндэсний Сайн дурын Илтгэл боловсруулах цаг хугацааг харгалзан үзэж, Засгийн газрын Үндэсний Сайн дурын Илтгэл мэдээлэх ажиллагаанд хувь нэмэр оруулах байдлаар аудитын дүгнэлт, тайланг боловсруулах хугацааг тодорхойлж болно. Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн Өндөр түвшний чуулга уулзалт гэх мэт ТХЗ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын өндөр түвшний арга хэмжээний дараагаар аудитын дүгнэлт гаргахаар цаг хугацааг тохируулах нь зохистой байж болох юм.

Уншигчдад ээлтэй, ойлгомжтой тайлан бичих зөвлөмж



(Канадын Аудит ба Хариуцлагын Сан, Үр дүнтэй тайлан бичих сургалт)



ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тайланг өргөн хүрээтэй, олон төрлийн сонирхогчид хэрэглэх тул уншигчдад ээлтэй, **ойлгомжтой** тайлан гаргах нь чухал. Зарим АДБ-үүд тайлангийн хэлбэр загварыг тодорхойлохдоо харилцааны мэргэшсэн мэргэжилтнүүдээр тайлангаа хянуулж, засварлуулдаг. АДБ-ын аудиторууд «уншигдах байдлын индекс» гэх мэт хэрэгслүүдийг ашиглаж болно. Канадын Аудит ба Хариуцлагын Сан нь уншигчдад ээлтэй, ойлгомжтой тайлан бичих практик зөвлөмжийг боловсруулсан.

Эцсийн бөгөөд хамгийн чухал шалгуур бол **тэнцвэртэй** тайлан бичих явдал юм. Тайланг бичихдээ АДБ-ын аудитор үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд Засгийн газар юуг сайн гүйцэтгэсэн, юуг сайжруулах шаардлагатай байгааг тодорхой илэрхийлэх шаардлагатай. Тэнцвэртэй тайлан бичихэд АДБ-ын аудитор нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын зорилгын талаар тэнцвэртэй аудитын дүгнэлт боловсруулах нь чухал. ТХЗ-ын тэнцвэртэй аудитын тайлан нь засгийн газрыг сайн хийсэн ажлаа үргэлжлүүлэн хийхийг уриалж, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, салбар яамд, холбогдох төрийн байгууллагуудад өөрсдийн хариуцаж буй үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд юу хийж болох талаар мэдээлэл өгөх замаар үнэ цэн бий болгодог.

Доорх зурагт АДБ-ын аудитор ТХЗ-ын аудитын тайлан бичих үйл явцыг харуулав.



ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийх энэхүү үйл явцыг дагаж мөрдөхөд АДБ-ын аудитор олон төрийн байгууллага, агентлагаас албан ёсны тайлбар



авдаг тул харилцааны тодорхой бэрхшээлтэй тулгарч болзошгүй. Төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагын тодорхой бус байдал, давхардал оршин буй нөхцөлд бэрхшээлийг улам хүндрүүлдэг. Иж бүрэн тайлан бичих, мэдээллийн нууцлалыг хадгалах хоёрын дунд зохих тэнцвэрийг сахих нь анхаарал татах асуудал болдог.

Аудитын тайланд ихэвчлэн аудитын хамрах хүрээнд тусгагдаагүй гуравдагч этгээдэд хамаарах мэдэгдлүүд багтдаг. ТХЗ-ын аудитын хувьд, ялангуяа олон талын оролцоог дэмжин, ИНБ-уудын өргөн хүрээтэй үйл ажиллагааг авч үздэг тул дээрх нөхцөл байдал үүсэх магадлал өндөр байдаг. Гуравдагч этгээдэд тайлангийн төслийг хүргэж, тэдэнд хамаарах мэдэгдлүүдийн үнэн зөв, иж бүрэн байдлыг шалгахад оролцоулах нь тайлангийн бодитой байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ АДБ-уудад тайлангийн үнэн зөв, шударга илэрхийллийг хангах боломжийг олгодог.

5.3. Үндэсний зорилт биелэлтийн явцын талаархи аудитын тайланг түгээхдээ хэнийг ч орхигдуулахгүй байх

АДБ-ын ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тайлан нь үндэсний зорилтыг хэрэгжүүлэлтийг дэмжих, хариуцлагатай байдал, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүчирхэг хэрэгсэл юм. Энэхүү тайлан нь ТХЗ-ын хэрэгжилтэд хараат бус, хөндлөнгийн хяналт тавих АДБ-ын үүргийг бэхжүүлж, нэр хүндийг өсгөнө. Эдгээр чиг үүргээрээ ялгаатай, оролцогч талуудын олон талт байдлыг харгалзан үзвэл аудитын тайланг түгээхдээ хэнийг орхигдуулахгүй байхад анхаарах шаардлагатай.



АДБ аудитын тайланг түгээхдээ баруун талд үзүүлсэн гурван асуудлыг авч үзэх хэрэгтэй. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тайланг үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшинд төрийн болон төрийн бус олон талын оролцогчид сонирхдог. Сонирхогчид нь засаглах эрх бүхий этгээдүүд, хууль тогтоох байгууллага, хууль тогтоох байгууллагын дэд хороо, иргэд, ИНБ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, НҮБ-ын байгууллагууд, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагууд, хөгжлийн түншүүд, олон улсын байгууллагууд байдаг. Сонирхогч талуудын шинжилгээг гүйцэтгэн, аудитын тайланг хүргэх шаардлагатай талуудын жагсаалтыг гаргахыг АДБ-т зөвлөж байна. Энэхүү жагсаалтыг гаргахдаа тухайн улсын эмзэг бүлгийнхнийг мөн анхаарч үзэх нь чухал юм. Зорилтот талуудад хүрэх, тэдэнтэй харилцах арга хэрэгслийг шийдэхдээ АДБ нь зорилтот талуудын сонирхол, нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Жишээлбэл, зарим зорилтот бүлэгт олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэбсайтаар дамжуулан хандах боломжтой байхад зарим нь илүү албан ёсны харилцааны суваг шаардаж магадгүй юм. АДБ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, газарзүйн байршлын хувьд алслагдсан бүс нутагт амьдардаг, бичиг үсгийн бэрхшээлтэй гэх мэт эмзэг бүлгийнхэнд онцгой анхаарал хандуулах ёстой.

5.4. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнг тайлагнах

- ✓ Аудитын тайлан нь иж бүрэн, үнэмшилтэй, ойлгомжтой, тэнцвэртэй, хугацаандаа боловсруулагдсан байна уу?
- ✓ Аудитын шалгалтаар илэрсэн сул тал, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахуйц үр дүнтэй зөвлөмж өгсөн үү?
- ✓ АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд аудитын тайлантай танилцах боломж бүгдэд нээлттэй байна уу?
- ✓ Аудитын баг нь тайлагнах үе шатанд шалгагдагч байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтарч ажилласан уу?
- ✓ Аудитын баг нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнг тайлагнахдаа мэргэжлийн үнэлэмж ашигласан үү?
- ✓ Аудитын баг нь ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнг тайлагнахдаа АДБ-ын ёс зүйн дүрэм, хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн үү?
- ✓ Аудитын баг ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр дүнг тайлагнахад шаардлагатай үр чадвартай байсан үү?
- ✓ ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын тайлагнах явцад зохих ёсны хяналт тавигдаж байсан үү?

- ✓ Тайлангийн агуулга, зөвлөмж боловсруулалт, тайланг түгээхтэй холбоотой гаргасан шийдвэрийн талаар зохих баримтжуулалт хийгдсэн үү?

5.5. Аудитын үр өгөөж

АДБ-ын аудитор аудитын тайланг бэлтгэхдээ аудитын үр нөлөөтэй холбоотой дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай

- Тайланд тусгагдсан зөвлөмжүүд аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэх үү?
- Зөвлөмжүүд нь эмзэг бүлгийнхний асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэх үү?
- Тайланг бүх гол оролцогч талууд, тэр дундаа эмзэг бүлгийнхэн хэрэглэх боломжтой юу?

VI. БҮЛЭГ.

АУДИТЫН МӨРӨӨР ХЯНАЛТ ТАВИХ, ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АУДИТЫН ҮР ӨГӨӨЖ



ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд АДБ нь аудитыг өндөр чанартай хийхээс гадна аудитаар зорьсон үр өгөөжийг хүргэх нь чухал юм. Өмнөх бүлгүүдээр бид аудитын үе шат бүрээс гарах үр өгөөжийг онцлон харуулсан. Ингэснээрээ бид аудитын үр өгөөжийг аудитын тайлан бэлтгэгдсэний дараа бодож үзэх зүйл биш бөгөөд үүнийг төлөвлөлтөөс эхлэн, аудитын бүх үе шатанд анхааран хэрэгжүүлэх ёстой зүйл гэдгийг тайлбарласан. Энэ бүлэгт бид аудитын тайланг нийтлэсний дараагаар хэрхэн аудитын үр өгөөжийг хүргэх тухай үйл ажиллагааны талаар тусгах болно.

Энэ үе шатанд АДБ ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр өгөөжийг хэрхэн сайжруулах талаар тунгаахдаа гурван үйлдлийг авч үзэх шаардлагатай.

6.1. ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөрөөр хяналт тавих

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөрөөр тавих хяналт гэдэг нь аудитын үр дүнд үндэслэн хариуцагч талын хийсэн залруулах арга хэмжээг АДБ-ын аудитор шалгахыг хэлнэ. Аудитын тайлангийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа нь аудитын үр өгөөжийг бататгаж, ирээдүйн аудитын ажлыг сайжруулах үндэс суурийг тавьдаг. АДБ нь бүрэн эрх, аудитын туршлага, хүчин чадлаас хамааран мөрөөр хяналт тавих үйл ажиллагаанд хэд хэдэн аргаас тохиромжтой байдлаар хэрэгжүүлэх боломжтой. Эдгээр аргууд нь хариуцагч байгууллагын удирдлагатай уулзалт хийх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тогтмол хугацаанд бичгэн мэдэгдэл ирүүлэхийг хүсэх, үтсаар холбогдох эсвэл талбар дээр хязгаартай очих, бусад аудитын багаар дамжуулан мэдээлэл цуглуулах эсвэл мөрөөр хяналт тавих тусгай аудитыг гүйцэтгэж болно.

Практик зөвлөмж

Мөрөөр тавих хяналт нь тогтоосон үе шатуудын дагуу үндэсний зорилгод биелэлтэд гарсан явцыг хянах ажиллагааг хамруулж болно.

Үндэсний зорилт биелэлтийн явцад хяналт тавихын зэрэгцээ аудитын загварын матрицыг ашиглан, гарсан үр дүнг харьцуулан дүгнэх боломжтой.

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитад мөрөөр хяналт тавих тусгай аудит нь зохимжтой байдаг. АДБ зөвлөмж хэрэгжилтийн явцыг хянахаас гадна, хамгийн чухал нь үндэсний зорилт биелэлтэд гарч буй ахицыг үнэлэх боломжтой.

Хэрэв АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд хийгээд хүчин чадлын хувьд зохимжтой бол аудитын тайлан хүргүүлсний дараагаар АДБ нь хариуцагч байгууллагад зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягтын загвар илгээж болно. Загвар нь өгсөн зөвлөмж, хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцагч тал, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүн (боломжтой тохиолдолд үр дүнг тоогоор илэрхийлэх) зэргийг багтаасан байна.

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг тухайн аудитыг гүйцэтгэх зорилгоор нэгдсэн олон салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг хэрэгжүүлдэг тул аудитын мөрөөр тавих хяналтыг зохион байгуулах зохистой бүтэц, үүрэг, хариуцлагыг тодорхойлох шаардлагатай болдог. АДБ-аас мөрөөр хяналт тавих ажиллагааг дэмжих зорилгоор мэдээллийг тогтмол цуглуулах төвлөрсөн газар хэлтсийг үүсгэж болох ба мөрөөр хяналт тавих аудитыг хэрэгжүүлэх олон салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн аудитын баг гүйцэтгэж болно. Мөн АДБ нь ТХЗ-ийн хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэх, аудитын мөрөөр хяналт тавих тусгай баг гаргахаар шийдвэрлэж болно.

АДБ-д ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын багцад ТХЗ-ын хэрэгжилтийн мөрөөр хяналт тавих аудитыг багтааж, холбогдох хугацаанд АДБ-ын жилийн төлөвлөгөөнд оруулахыг зөвлөж байна.

6.2. Гол асуудлыг харилцах

ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын гол асуудлыг харилцах нь аудитын үр өгөөжийг бий болгоход ихээхэн ач холбогдолтой. АДБ энэ зорилгоор үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд хэд хэдэн ялгаатай харилцах сувгийг ашиглаж болно:

- Үндэсний хэмжээнд АДБ-аас хэвлэлийн мэдээ, хэвлэл мэдээллээр ярилцлага өгөх, бага хурал, панел хэлэлцүүлэг, мэргэжлийн байгууллагуудын дамжуулан арга хэмжээ зохион байгуулах, НҮБ -ын агентлагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцох, ИНБ-уудтай хамтран арга хэмжээ зохион байгуулах гэх мэтийг ашиглан гол асуудлыг харилцаж болно.
- Бүс нутгийн түвшинд АДБ нь АДБОУБ-ын бүсийн байгууллага, НҮБ, бусад бүс нутгийн хэлэлцүүлэг, хөгжлийн түншүүдийн зохион байгуулах арга хэмжээнд оролцох байдлаар харилцаж болно.
- Олон улсын түвшинд АДБ нь НҮБ-ын агентлагуудын зохион байгуулах уулзалт, OECD, INCOSAI болон бусад АДБОУБ арга хэмжээ, Дэлхийн банк, олон улсын ИНБ-ууд гэх мэт олон улсын байгууллагуудын зохион байгуулах арга хэмжээгээр дамжуулан асуудлыг харилцаж болно.
- Сошиал медиа платформ, аппликейшн нь гол асуудлыг харилцах АДБ-ын хүчирхэг хэрэгсэл болж чадна.

- Гүрж улсад засгийн газрын төсвийн цахим хяналтаар дамжуулан ТХЗ-ын талаархи болон түүнтэй холбоотой бүх аудитын талаархи мэдээллийг өгдөг. Ард иргэд нь ТХЗ-ын талаар хүсэлт гарган, энэ нь цаашид хийгдэх аудитад асуудлыг хэлэлцэх боломжийг бүрдүүлдэг.
- Номхон Далайн АДБ-ын Холбоо нь ТХЗ-ын эргэн тойронд хийж буй АДБ-ын ажлын үнэ цэн, ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд бүс нутгийн залуу хүн ам болон бусад олон талуудад мэдээлэл түгээх зорилгоор харилцаа холбооны олон төрлийн хэрэгслийг ашиглах тухай харилцаа холбооны стратеги боловсруулахаар төлөвлөж байна.
- OLACEFS-ийн Мэдээлэл, харилцаа холбооны технологийн комисс нь UNDESA-ийн оролцоотойгоор онлайн аппликейшн боловсруулсан бөгөөд энэ нь ТХЗ-ын тодорхой зорилго, зорилттой холбоотой бүс нутгийн АДБ-аас хийсэн аудитын бүх тайланг харах боломжийг олгодог.

АДБ-ууд аудитын зөвлөмж, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар засгийн газартай харилцах харилцааг хязгаарлахгүйгээр Үндэсний Сайн дурийн Илтгэл боловсруулах үйл явцад идэвхтэй хувь нэмэр оруулах боломжтой. АДБ нь жишээ нь, ҮСДИ-ийг бэлтгэхэд оролцох, эсвэл улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад албан ёсны төлөөлөгчөөр нэгдэх боломжтой.

ТХЗ-ын аудит нь улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад эсвэл бүс нутгийн хянан хэлэлцэх хэлэлцүүлэгт (НҮБ-ын Бүсийн Комиссын шугамаар) илтгэл тавих замаар 2030 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах механизм, ТХЗ-ын мөрөөр хяналт тавих үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж, эерэг нөлөө үзүүлж болно.

6.3. Талуудын хооронд холбоо тогтоох

Бид ТХЗ-ын хэрэгжилтэд аудит хийхдээ олон талын оролцоог хангахыг зөвлөдөг. Аудитын энэ үе шатанд ч олон талын хамтын ажиллагааг ханган, тэдэнтэй холбоо тогтоох нь чухал юм. Аудитын өмнөх үе шатанд хийсэн оролцогч талуудын болон RACI шинжилгээ нь аудитын мөрөөр хяналт тавих үе шатанд ч мөн ашиглагдана. АДБ-ын аудитор аудитын өмнөх үе шатанд бий болсон харилцаандаа суурилан олон талтай холбоо тогтоож болно. Аудитын явцад олон талын хамтын ажиллагааг хангаснаар АДБ-аас хийсэн ажил, өгсөн зөвлөмжийг талууд биечлэн ойлгож, ухамсарлан хүлээж авах нөхцөлийг бүрдүүлдэг. Үндэсний, аймаг, орон нутгийн засаг захиргаа, хууль тогтоох байгууллага, шүүх, ИНБ, ард иргэд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагууд, НҮБ-ын агентлагууд, олон улсын байгууллагууд, хөгжлийн түншүүд, хэвлэл мэдээлэл, сэдвийн хүрээнд мэргэшсэн мэргэжилтнүүд, хувийн хэвшил, АДБОУБ-ын байгууллагууд болон АДБОУБ бүсийн байгууллагууд нь аудитад хамаарах олон тал байж болно. Энэхүү харилцаа нь нэг удаагийн хамтын ажиллагаанаас эхлээд стратегийн түншлэлд суурилож болно. Жишээлбэл, Индонезийн АДБ нь ТХЗ-ын аудитын багт дэмжлэг үзүүлэх үүднээс их сургуулийн судалгааны төвүүдтэй стратегийн түншлэл бий болгосон.

6.4. АДБОУС шалгах хуудас: ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын мөрөөр тавих хяналтын тайлан

- ✓ АДБ ТХЗ-ын хэрэгжилтийн урьд урьдны аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд зохих ёсны мөрөөр тавих хяналт хэрэгжүүлсэн үү?
- ✓ АДБ аудитын дүгнэлт, залруулах арга хэмжээний нөлөөллийн талаар хууль тогтоох байгууллагад мэдээлсэн үү?
- ✓ Аудитор нь шалгагдагч байгууллага боломжит хугацааны асуудлыг зохих


ёсоор шийдвэрлэж, суурь шалтгааныг засч залруулж чадсан уу гэдэгт анхаарлаа хандуулсан уу?

- ✓ Аудитын баг нь мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад шалгагдагч байгууллага болон бусад оролцогч талуудтай хамтарч ажилласан уу?
- ✓ Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад аудитын баг мэргэжлийн үнэлэмж ашигласан уу?
- ✓ Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад аудитын баг нь АДБ-ын ёс зүйн дүрэм, хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн үү?
- ✓ Тус багт ТХЗ-ын хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай үр чадвар байсан уу?
- ✓ Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад аудитын багт ёсны хяналт тавигдаж байсан уу?
- ✓ Аудитын мөрөөр хяналт тавих үе шаттай холбоотой зохих баримтжуулалт хийгдсэн эсэх?

6.5. Аудитын үр өгөөж

АДБ-ын аудитор нь мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад аудитын үр өгөөжтэй холбоотой дараах асуултуудыг тавьж болно

- Аудитын үр өгөөжийг хамгийн их байлгахын тулд аль оролцогч талуудад анхаарлаа хандуулах ёстой вэ?
 - АДБ-аас ТХЗ-ын хэрэгжилтийн аудитын үр өгөөжид мониторинг хийх үр дүнтэй хяналтын механизмыг хэрхэн бүрдүүлж болох вэ?
 - АДБ ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд оруулсан эерэг хувь нэмрээ хэрхэн зохистой илтгэж, тайлагнаж болох вэ?
 - АДБ аудитын үр өгөөжийн талаар тайлагнахдаа хэрхэн хүйсийн тэгш эрх, хүртээмжтэй байдлыг анхаарч ажиллах вэ?
-



www.idi.no

